



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-43</i>
<hr/>	
<i>1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>4-43</i>

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодын
03 дугаар сарын 19-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 34 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 55.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 44 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Л.Мөнхбаатар, Н.Наранбаатар, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж;
Чөлөөтэй: Б.Бейсен, Ц.Даваасүрэн, Ш.Раднаасэд, Д.Тогтохсүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Саранчимэг.

Нэг.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын референт Д.Батсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, мөн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөрс, үр сортын хэлтсийн дарга Н.Оюунсүвд, Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Төсвийн байнгын хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Х.Баделхан, Ц.Туваан, Д.Өнөрболор, Г.Мөнхцэцэг, Б.Чойжилсүрэн, Г.Ганболд, Ж.Батсуурь, Ц.Цэрэнпунцаг, Ж.Батжаргал, Ц.Идэрбат, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол

Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Батсуурь, Ц.Цэрэнпунцаг, Ч.Хүрэлбаатар, Х.Болорчулуун, Г.Тэмүүлэн нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хамтарсан хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 38 минут үргэлжилж, 34 гишүүнээс 24 гишүүн хүрэлцэн ирж, 61.5 хувийн ирцтэйгээр 17 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин
Д.Сүхбаатар” танхим 14 цаг 44 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Гишүүддээ энэ өдрийн мэндийг айлтгая.

Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сарын 19-ний өдрийн 2 Байнгын хорооны хамтарсан хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Та бүхэнд өнөөдөр хуралдах Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороо болон Төсвийн Байнгын хорооны хамтран хуралдах Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Төсвийн Байнгын хорооноос Ганибалын Амартүвшин гишүүн, Цогт-Очирын Анандбазар гишүүн, Хавдисламын Баделхан гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Болдын Жавхлан гишүүн, Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Чимэдийн Хүрэлбаатар гишүүн, Баттогтохын Чойжилсүрэн, гишүүд, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүд хүрэлцэн ирсэн байна. Нийт 19 гишүүн оролцохоос 12 гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Байгаль орчны Байнгын хорооноос оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Давтагдсан гишүүдийг дурдахгүйгээр Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Хаянгаагийн Болорчулуун гишүүн ирсэн байна. Гочоогийн Ганболд гишүүн, Гонгорын Дамдинням гишүүн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн Цэвэгдоржийн Туваан гишүүн, Цэдэндалмын Цэрэнпунцаг гишүүн, Пүрэвдорж гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Ингээд Байнгын хорооны хуралдааны ирц нийт 34 гишүүн байхаас 19 гишүүн хүрэлцэн ирж 55.9 хувийн ирцтэй байгаа тул өнөөдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Нэг асуудал байгаа.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл Засгийн газраас 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудал байгаад байгаа.

Засгийн газраас хэлэлцэх асуудлын тов дарааллын харгалзахгүйгээр Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх хүсэлтийг ирүүлж үүний дагуу Улсын Их Хурлын даргын захирамж бол гарсан байна. Үүнтэй холбогдуулж 2 Байнгын хороонд хамтран хуралдаж энэ асуудлыг шийдвэрлэх хэлэлцэх энэ чиглэлийг бол өгсөн байгаа. Ингээд энэ дагуу өнөөдрийн хуралдаан хуралдаж эхлэх гэж байна аа. Ингээд Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга Дашизэвэгийн Амарбаясгалан дарга танилцуулна аа. Амарбаясгалан даргын микрофоныг өгье. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Хуралдаанд мөн Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн бас нэмэгдэж ирсэн байна.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 10 аймаг 37 сумд төмөр зуд, 16 аймгийн 130 сумд цагаан зуд, 14 аймгийн 49 сум нийслэлийн 4 дүүрэгт цагаанаар зудрах уу. Нийт 21 аймгийн 216 сум, нийслэлийн 4 дүүрэгт хаваржилт хүндэрсэн байна аа. Улмаар 03 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт малын 7.3 хувь

буюу 4.7 сая мал зүй бусаар хорогдоод байна. Аймаг сумдын аюулгүй нөөцөд нийт 27.2 мянган тонн өвс, 11.7 мянган тонн тэжээл бэлтгэснээс 03 дугаар сарын 12-ны байдлаар 2.1 мянган тонн өвс, 1 мянган тонн тэжээлийн үлдэгдэлтэй, Өвөрхангай, Орхон, Дундговь, Архангай аймгууд өвс тэжээлийн нөөцөө бүрэн дуусгаад байна. Өвс тэжээлийн хомсдолоос шалтгаалан 1 кг хивгийн үйлдвэрийн үнэ 950-1100 төгрөг хүртэл өссөн байна.

Иймд зудын хүндрэлд нэрвэгдсэн иргэдэд ирэх дарамтыг бууруулах, малын тэжээл, тэжээлийн нэмэлтийн үнийг тогтворжуулахын тулд гаалийн албан татвараас чөлөөлөх шаардлага үүсээд байна.

Хоёрдугаарт, Монголчуудын хүнсний гол хэрэглээний нэг болох гурилын үнэ сүүлийн 4 жилд 2 дахин өсөөд байна. Гэвч гурилын гол түүхий эд болох улаан буудайн үнэ сүүлийн 4 жилд 24 хувиар өсжээ. Энэ нь гурилын зах зээлийн үнэ нь зүй бусаар тогтож өрсөлдөөн хязгаарлагдсан байна гэх дүгнэлт тэд хүргэж байна аа. Иймд үнийн өрсөлдөөнийг дэмжих гол нэрийн бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор импортлох мал амьтны тэжээл тэжээлийн нэмэлт болон улаан буудайн баяжуулсан гурилыг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан болно.

Монгол Улсын Их Хурлын гишүүд ээ,

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Тэмүүлэн: Амарбаясгалан даргад баярлалаа. Хуралдаанд оролцож

байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя.

Чимэдийн Хүрэлбаатар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Болдын Жавхлан сангийн сайд, Хаянгаагийн Болорчулуун ХХААХҮ-ийн сайд, Шаравын Мөнхцэрэн Монгол Улсын ЗГХЭГ-ын салбарын бодлого зохицуулалтын газрын дарга, Даваасүрэнгийн Довчинсүрэн ХХААХҮЯ-ны хүнсний үйлдвэрийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Гэлэгжамцын Наранчулуун ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Нофын Оюунсувд ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөрс, үр сортын хэлтсийн дарга, Энхбаатарын Цолмонжаргал ХХААХҮЯ-ны Төрийн захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга, Даваасүрэнгийн Батсүрэн ЗГХЭГ-ын Салбарын бодлого зохицуулалтын газрын референт гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна аа.

Ингээд Засгийн газраас өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Болорчулуун гишүүнээр тасаллаа. Дамдинням гишүүн асуулт асууя.

Г.Дамдинням: Энэ гаалийн албан татвараас бас энэ гурил, хивэг гээд энэ ард түмний амьдрал хүнд байгаа үед чөлөөлөх зайлишгүй шаардлагатай үнэ нь огцом өсчихсөн хомс луу ороод байгаа энэ бараа бүтээгдэхүүнийг чөлөөлөх хуулийн төсөл орж ирж байгааг дэмжиж байна. Тойргоороо явсан ард иргэдтэйгээ уулзсан. Уулзаад явж байхад бол энэ гурилын үнэ дээр маш их гомдол тавьж байна аа.

Нөгөө талдаа тариаланчидтайгаа уулзаад явахтай зэрэг тариаланчдад бас энэ гурилын үнийн өсөлтөөс яг

тариаланчид нь авч байгаа нь их бага байгаад байна. Үйлдвэрүүд дээрээ хамаг орлого ашиг нь явчхаад байна гэдэг ийм юмыг ярьж байна. Тэгэхээр бид нар энэ тариаланчид гэдгийг бол яг энэ зах зээлийн яг энэ бүтцээр нэг хараад үзвэл бид нар тариаланчдыг энэ гурилын үйлдвэрүүдээсээ бас тусдаа авч харах ёстой юм байна лээ. Ингээд энэ импортын татвараас нь чөлөөлөөд хаячихтай зэрэг баахан хямд гурил тэгээд л хивээг орж ирнэ. Энэ нь ард түмэнд хэрэгтэй, малчдад хэрэгтэй. Гэхдээ энэ цаана нь бас энэ тариаланчдаа ер нь яах вэ? Гурилын үйлдвэрүүд бол энэ дээр бараг 4, 5 нугалсан ашиг гэх үү, өсөлт хийж байгаа юм байна гэдгийг бол түрүүний тоо баримтын Засгийн газраас гаргаж ирсэн мэдээллээс харлаа.

Тэгэхээр энэ зах зээлийн энэ гинжин хэлхээн дотор байгаа нэг хэсэг нь хэтэрхий их ингэж аваад байж болохгүй учраас Засгийн газрын зохицуулалт хийх нь зүй ёсны хэрэг зөв. Тэгэхээр одоо 2 асуулт байгаа юм.

Нэгдүгээрт, энэ тариаланчдаа ер нь яаж хамгаалах вэ? Одоо хаврын тариалалт эхлэх гээд байна. Тариаланчдынхаа зуны халуун намрын халуунд ингэж зүтгэж бороо шуурганаас хамгаалж хамаг байдгаараа зүтгэж ургуулсан энэ тариа будаа энэний үнэ хэцүү байдалд орчихно. Энэ хүмүүс чинь бас зээл авах ёстой болно. Эргэлт хийх ёстой болно. Тэгэхээр энэ хүмүүсийг ер нь хамгаалах дэмжих ямар бодлого хийх юм. Ер нь улс орнууд бол ер нь энэ хүмүүстээ бол энэ чиглэлдээ бол бас татаас өгөөд л явдаг л юм байна лээ л дээ. Тэгээд 1 дүгээр асуулт бол энэ.

Хоёрдугаарт, энэ тариаланч ногоочидтой уулзаад явж байхад бас нэг засгийн хэрэгжүүлж байгаа бас энэ Их Хурал Засгийн газраас гаргаж байгаа бодлогуудаас нэг зүйлийг маш их дэмжиж байгаа юм, 2 юмыг.

Нэгдүгээрт бол энэ 3 хувийн зээл өгөөд 2 жилийн хугацаатай болгож өгсөн. Хуучин нэг жилийн хугацаатай байсан хүү нь өндөр байсан. Тэгэхээр энэ зээлээ ер нь үргэлжлүүлэх үү? Одоо 5 хувь болоод буцаад өсчихсөн юм байна, 2 жилийн хугацаатай болоод хэвээрээ. Тэгэхээр энийг 3 жил болгоод өгөөч, 5 жил болгоод өгөөч, хүүг нь бууруулаад өгөөч гэдэг ийм л хүсэлт тавиад байна л даа. Тэгэхээр засаг дээр энэ дээр ямар бодлого хийж байгаа вэ? Энэ бол яг бодитой дэмжлэг болоод яваад байгаа юм байна лээ. Хүмүүст яг энэ ногоо тарьж байгаа, будаа тарьж байгаа, тариалан эрхэлж байгаа хүмүүстээ хамгийн том тус дэм юм байна лээ. Тэгээд энэ 100000-ын дэмжлэг бол энэ тариа ногоонд ч бүгдэд нь өгч байгаа нь бол бас их талархал хүлээж байгаа юм байна лээ. Тэгээд энэ салбарыг бас нэг амьтай голтой байлгаад байх ёстой юм болов уу? Яалт ч үгүй энэ онцгой салбар учраас бид нар анхаарах ёстой.

Тэгэхээр энэ 2 асуултад хариулж өгөөч ээ.

Г.Тэмүүлэн: Дамдинням гишүүний асуултад хариулъя. Амарбаясгалан дарга.

Д.Амарбаясгалан: Гурилын үнэ бол зүй ёсныхоо нэмэгдлээс бол халиад явчихжээ гэж дүгнэж байгаа. ШӨХТГ-аас энэ үнийн асуудал дээр удаа дараагийн шалгалт хийж, үгсэн хуйвалдаж үнээ үндэслэлгүйгээр нэмжээ гэдгийг бол тогтоож акт тавьсан. Улмаар шүүх дээр энэ асуудал нь шилжээд өнөөдрийг хүртэл эцэслэн шийдэгдэхгүй ахиад жил орчмын хугацааг өнгөрч байгаа. Ийм л байдалтай байгаа. Тэгэхээр энэ шударга өрсөлдөөний асуудал цаашилаад энэ салбарын монополын асуудал нь өөрөө энэ ШӨХТГ-аас тавьж байгаа актын хэмжээнд шийдэгдэж чадахгүй болжээ гэдэг нь тодорхой болж байгаа юм. нөгөө талдаа төр бол энэ стратегийн бүтээгдэхүүн гэдэг утгаар гар нь гурил улаан буудай зэрэгт бол нэг талдаа хамгаалалт нөгөө талдаа дэмжлэгийг

үзүүлээд яваад байгаа юм. Үр дүнгээр нь юу болчхов гэхээр монопол тогтчихлоо гэж байгаа юм.

Яг хилийн цаана улаан буудайн 1 дүгээр гурил 900 гаран төгрөгийн үнэтэй байхад дотоодын зах зээл дээр 2600-аас 3 мянган төгрөгийн үнэтэй болж зарагдаж байгаа байдал нь өөрөө хиймэл үнийн өсөлтийг хийсэн байна гэдэг дүгнэлтийг бодитой гаргах шалтгаан болчхож.

Дэлхийн зах зээл дээр улаан буудайн үнэ өөрөө 100 доллароос хамгийн өндөр түвшиндээ хүрэхэд 200 долларт хүрч байгаа юм. Энэ жишгийг Монгол тал Монголчууд барьж байна уу гэвэл ер нь 200 доллар орчимдоо улаан буудайн үнийг бариад байгаа юм. Гэтэл улаан буудайгаар үйлдвэрлэж байгаа гурилын үйлдвэрлэлийн өртгийн 90 хувийг бүрдүүлж байгаа улаан буудайн үнийн өртөг цаашилаад 2600-аас 3 мянган төгрөг болтлоо өсөж байгаа байдал нь бол зүй бус байна гэж ингэж Засгийн газраас үзсэн. Тэр ч утгаараа энэ гурилын үнийг чөлөөт өрсөлдөөний зарчмаар бодит үнэдээ очих тэр нөхцөлийг бүрдүүлэх үүднээс импортын татварыг чөлөөлөх, мөн хэмжээ тавихгүйгээр асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэж ингэж Засгийн газрын зүгээс үзсэн байгаа. Нөгөө талдаа энэ тариаланчдын эрх ашгийн асуудал энд давхар хөндөгдөж байгаа.

Тэгэхээр тариаланчид мэдээж стратегийн бүтээгдэхүүн тарих ургуулах энэ том үүргийг хүлээгээд ажиллаж байна. Олон улсынхаа жишгээр нэг бол дэмждэг, нэг хамгаалдаг ийм 2 том жишиг байгаад байгаа юм. Монголчууд Монгол Улсын хувьд бол дэмждэг, дэмжлэг үзүүлдэг, хамгаалдаг хоёулаа өөрөө үр дүнгээ бүтэн өгч чадахгүй байгаа. Ийм үр дүн гарч байгаа учраас Засгийн газрын зүгээс тариаланчдыгаа одоо энэ тариалалт хийж байгаа нөхцөл бизнес хийж байгааг нь хамгаалах бодлогыг бол тогтвортой барина. Хамгаалалт гэдэг нь бол нэг талдаа үнийн

эрсдэлээс хамгаалах ёстой зах зээлийн үнээс доогуур орж эрсдэл учрах юм бол хамгаалалтыг төр үзүүлдэг. Нөхөн олговрыг олгодог. Байгалийн гамшиг давагдашигүй хүчин зүйлээс үүссэн нөлөөлөл дээр эрсдэл учрах юм бол мөн төр хамгаалдаг энэ бодлогыг барих нь зүйтэй. Нөгөө талдаа бол гурил үйлдвэрлэн зах зээлийнхээ зарчмаар өрсөлдөөний зарчмаар үнэ нь ард түмний хэрэглээнд дарамт учруулахгүй хэмжээнд очих ёстой гэсэн энэ зүйл дээр анхаарч ажиллаж байгаа.

Ногоочид буюу өрхийн аж ахуй эрхэлж байгаа хэсэгтээ бол Засгийн газрын зүгээс урт хугацааны хөнгөлөлттэй зээлийг үзүүлж ажиллаж ирсэн үр дүнгээ өгч байгаа. Өнөөдөр 3-аас 5 хувийн хүүтэйгээр энэ хөтөлбөр хэрэгжсэнээр амьжиргааг дэмжих чухал бодлого болсон гэж ингэж Засгийн газрын зүгээс үзэж байгаа.

Цаашидаа ганц ногоочид гэлтгүйгээр ер нь хөдөө аж ахуйн салбарт энэ ажиллаж байгаа бичил бизнес эрхэлж байгаа иргэдийг урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр дэмжих бодлогыг үргэлжлүүлнэ гэсэн ийм чиглэлтэй байгаа.

Г.Тэмүүлэн: Анандбазар гишүүн асуулт асууя.

Ц.Анандбазар: Баярлалаа. Энэ өвөл зөвхөн малчдын хувьд биш Монголын хөдөө аж ахуйн салбарын хувьд их том сорилт боллоо. Монголчууд маань олон өвөл олон зудыг үзсэн боловч ийм зүүдийг зудыг үзсэнгүй гэж малчид маань халаглаж байна. Юуны өмнө зудтай турхантай байгаа энэ хүнд хэцүү үед Засгийн газрын гишүүд маань бас хөдөө орон нутгаар их явж ажил амьдралтай нь өөрийн биеэр танилцаж малчдын хүндэрч байгаа асуудлыг өөрсдөө үзэж танилцсанд хөдөөгийн гишүүд их талархалтай байгаа. Яагаад гэвэл анх удаа Засгийн газар маань өмнө нь зуд дээр ингэж ажиллаж байсныг сайн мэдэхгүй

байна гэж малчид ярьж байгаа. Маши сайхан сэтгэл гаргаж туслалцаа үзүүлж тэрэг техникээс авхуулаад тусламжийн гараа сунгалаа. Цэргийн ангиуд өвөл сайхан хуарандаа байдаг байсан зам гаргаж тусаллаа. Олон сайхан сэтгэлтэй ажил явлаа. Тэгээд болж байгаа бүтэж байгаа юмыг бас сайхан хэлэх ёстой байх гэж бодож байна.

Тэгээд бодлогын 2, 3 асуулт асууя. Юуны өмнө Амарбаясгалан даргаас энэ зуд энэ жил болоод дуусаж байгаа юм биш ээ. Хойд мөсөн далай өмнөд мөсөн далай хайлж байна. Дэлхийн цаг агаар геополитик бүхэлдээ өөрчлөгдөж байна аа. Ер нь олон улсын мэдээ мэдээнээс харах юм бол хур бороо тунадасны асуудал бол яваандаа нэмэгдэх юм байна. Ирэх жил энэнээс илүү зуд болж болохоор байна гэж CNN-ээр хүртэл ярьж байна. Тэгэхээр бид 30 жил боллоо шүү дээ мал аж ахуйн тухай сайн муугаар хэлж. Хэдэн ядарсан малчид маань мөнчгөрөөрөө энэ өвлийг маш сайхан давж байна.

Тэгэхээр ийм асуудал гаргахгүйн тулд цаашидаа Засгийн газрын том бодлого юу хэрэгжүүлэх гэж байна вэ? Бид гурилын аж ахуйг бүтэн шийдчихсэн шүү дээ. Өнөөдөр урд хөл бүдэрвэл хойд хөл гэдэг шиг гурилын үйлдвэрүүдийг шүүмжлээд эхэлж байх шиг байна. Гурилын бизнесийг бизнесийн салбарт хамгийн ашиггүй бизнес л гэж хэлдэг юм билээ.

Тэгэхээр энийг одоо нэг зүйлийг нь засах гээд нөгөөдхийг нь унагааж бас боломгүй юм шиг надад санагдаад байгаа. Болорчулуун сайдаас гурилын импортын татвар хэд байна, НӨАТ хэд байна гэдгийг тодруулж асуумаар байна. Тэгээд Амарбаясгалан даргын түрүүний асуулт дээр хэрвээ бид ХАА-гаа босгоё гэж бодож байвал энэ малын тэжээл тариалдаг асуудлыг бүхэл бүтэн бодлого болгож гаргамаар байна.

22 тэжээлийн аж ахуй социализмын үед байсан байна. Бүгдийг нь

хувьчлаад дампууруулсан, зах зээлийн шугамаар. Тэгэхээр энэ дээр энэ бүсийн сонгуулийн шинэ дүрэм гарсантай холбоотойгоор бүс хоорондын тэжээлийн аж ахуйг ирэх жил гэхэд байгуулмаар байна аа. Энэ онцгой чухал юм болно. Яагаад гэвэл хэрвээ аманд нь хийх хоол унд байх юм бол зуд гэж үг ер нь байдаггүй юм байна аа. Канад байна олон улс байна. Ийм малтай, аж ахуйтай. Тэжээлийн яг ургамал тариалдаг ийм бодлого Монгол Улсад маань байхгүй байна, 70 сая малтай атлаа. Тэгэхээр энэ бодлогыг өөрчлөхгүй бол дахиад зуд, дахиад гарна дахиад бид бүх мөнгөө савах гээд байна.

Тэгэхээр тэжээлийн ургамлыг бодлогын хэмжээнд тариалж шийдэхийн тулд газар тариаланг босгосон бодлогыг давтаж хэлмээр байгаа юм. Энэ дээр би танд юу хэлэх гэж байна гэхээр түли шатахууны хөнгөлөлттэй зээлийг тариаланчид олгодог. Энийг хиймээр байна. Бордоон дээр зээл олгодог энийг хиймээр байна. Тоног төхөөрөмжийн зээл олгодог энийг хиймээр байна. Хөнгөлөлттэй зээл, үрийн будааны дэмжлэг үзүүлдэг тариаланчдад энийг бас хиймээр байна. Ургамал хамгааллын бодисуудыг зээлээр олгодог энийг бас хиймээр байна, усалгаатай тариалангийн талбайг бодлогоор хиймээр байна. Ингэх юм бол ойрын 4 жилд Монгол үгийн сангаас зуд гэдэг үгийг хасаж болохоор байна. Энэ бол их том сургамж боллоо шүү дээ. Олон хүн амьдралаасаа хагацаж байна. Ийм бодлого хийхгүй бол ирэх жил дахиад зуд болохоор байна. Тэгээд муу амлаж байгаа юм биш энэ дэлхийн цаг агаарын асуудал байгаа.

Тэгэхээр гурил тэжээлийн.

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулж болно. Хариултын дараа. 5 номер Амарбаясгалан дарга.

Д.Амарбаясгалан: Мэдээж гурилын үйлдвэрүүд хөл дээрээ босчихсон. Тэгээд бизнесийн ашиг орлогыг өнөөдөр

бид нэг их айхтар өндөр бага гэж ярих нь бол зохисгүй байх гэж бодож байгаа юм. Харин бид олон улсынхаа түвшинтэй зах зээлийнхээ нөхцөл байдал ард иргэдийнхээ худалдан авах чадвартай нийцүүлж бас асуудалд хандах нь зүйтэй болов уу гэж түүрүүн би тодорхой хариулсан. Тариаланчдаас дунджаар тонн улаан буудайг 700 мянга орчмоор авдаг. Яг гурилд орж байгаа орц нь. Улаан буудай өөрөө 1кг гурил үйлдвэрлэхэд 90 хувийнх нь өртгийг бий болгодог зүйл. Гэтэл 700 төгрөгөөр авсан буудай маань гурил болоод 3 мянган төгрөг хүртлээ үнэ нь өсөж байгаа байдал дээр гурилын үйлдвэрүүд ашиггүй гэж ярих нь бол зохисгүй байх. Харин төрийн үзүүлж байгаа шат шатын дэмжлэг тусалцаа хэтэрчээ. Таны саяын хэлдгээр бүх шатад нь хөнгөлөлттэй зээл дэмжлэг хөнгөлөлтийг үзүүлчихсэн.

Эцсийн дүнд нь ард иргэд үнэтэй гурил хэрэглэж байгаа энэ байдалтай бол Засгийн газар эвлэрэхгүй гэж байгаа юм. Сүүлийн нэг жилийн хугацаанд энэ ШӨХТГ-аас анхаарал хандуулаад үгсэн хуйвалдаж үнээ нэмж байна гэдэг дээр акт тавиад байхад арга хэмжээ авагдаж чадахгүй байгаа учраас л Засгийн газар өнөөдөр импортын татварыг тэглэе, хугацаагүйгээр. Мөн дээрээс нь хэмжээгүйгээр энэ асуудлыг шийдэх нь зүйтэй. Яагаад ингэж орж ирж байгаа шалтгаан бол тодорхой хугацаанд тодорхой хэмжээтэйгээр энэ шийдвэрийг гаргахаар тэр шийдвэрт нийцүүлээд үйлдвэрлэлээ багасгадаг хомсдолыг нь бий болгодог үнээ тогтвортой барих бодлогыг бол хувийн хэвшлийнхэн тодорхой хэмжээнд монопол үүсгэгч нар хийгээд байна гэдэг нь энэ дүгнэлтээр гарч ирээд байгаа юм.

Тийм учраас Засгийн газар энэ дээр ажиллаж байна. Харин тариаланчдын үйл ажиллагаа явуулах нөхцөлийг дордуулахгүй байх тал дээр Засгийн газраас хамгаалалтыг бол өндөр түвшинд хийж зохион байгуулна. Гэхдээ хамгаалалтыг шууд татаас хэлбэрээр

хийх боломжгүй. Харин энэ олон улсын ялангуяа АНУ Энэтхэг зэрэг томоохон улс орнуудын хэрэгжүүлдэг нөхөн олговрын хөтөлбөрийг Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж ингэж үзэж байгаа юм. Нэг ёсондоо бол зах зээл бизнесийнхээ зарчмаар зохицуулагдаж байх ёстой.

Хэрвээ стратегийн ач холбогдолтой энэ бүтээгдэхүүн дээр эрсдэл учрах юм бол нөхөн олговрын асуудлыг шийдэж чаддаг. Энэ боломжийг бол нээх нь зөв юм гэж ингэж үзэж байна.

2 дахь зүйл зудын нөхцөл байдал хүнд байгаа. 2024 онд болж байгаа зуд урьд өмнөх жилүүдтэй харьцуулах юм бол сүүлийн 40-өөс 50 жилийн хугацаанд тохиолдоогүй их хэмжээний цас орсон, олон удаагийн давтамжтай. Мөн дээрээс нь их хүйтрэл бий болжээ. Хөрсөн дээрээ 40 градус хүртэл хүйтэрсэн энэ нөхцөл байдал бол малчид цаашилаад мал тэсвэрлэх ийм боломжгүй нөхцөлийг бол үүсгэж байна. Энэ нөхцөл нь дэлхийн цаг уурын өөрчлөлттэй холбоотойгоор бий болж байгаа бодитой өөрчлөлт байна гэж ингэж дүгнэж байгаа. Зундаа их халдаг, бороо их ордог, өвөлдөө их хүйтэрч байна цас нь их унаж байна. Энэ нөхцөлийг яг малчид маань 5 хошуу малаа 5 төрлөөр нь өсгөөд байгалийн бэлчээрээр даван гарна гэдэг нөхцөл бол цаашидаа улам бүүр хумигдаж байна.

Тэгэхээр малчид өөрсдөө өвс тэжээлээ бэлтгэх, малаа төрөлжүүлэн өсгөх, тэр боломж нөхцөлийг бүрдүүлэх чиглэл дээр Засгийн газраас тодорхой хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй гэж ингэж үзэж байна. Яг өнөөдрийн байдлаар 70-аас дээш хувийн хорогдолтой малаа хорогдуулсан малчид бол 4 мянга гаруй өрх болж бүртгэгдэж байна. Энэ онд эрсдэлийг 20 сая орчим мал хорогдох эрсдэлтэй. Үүнийг дагаад 20 гаруй мянган өрх малгүй болох эрсдэлтэй гэж ингэж тооцоолол урьдчилсан байдлаар гарсан. Тэгэхээр энэ нөхцөлд хүргэхгүйн тулд Засгийн газраас түргэн

шуурхай арга хэмжээг авч байна. Мөн дээрээс нь энэ малгүй болж байгаа хотоо харлуулж байгаа малчдыг цаашаа амьжиргаагаа залгах нөхцөл боломжоор нь хангах үүднээс.

Г.Тэмүүлэн: Болорчулуун сайд нэмж тайлбар өгөх үү.

Х.Болорчулуун: Та бүгд энэ өдрийн амрыг эрье ээ. Шударга бус өрсөлдөөний газрынхан энэ гурилын талаар бас шалгалт хийгээд акт тавьсан гээд тэр нь эцсийн байдлаар шүүх дээр бол шударга бус өрсөлдөөний газрын талд гараагүй л юм билээ. Хоёрт тэр шударга бус өрсөлдөөний тэр дарга байсан Мөнхчулуун гээд нөхөр Засгийн газар дээр орж ирээд тайлбарлахдаа маш худлаа мэдээллийг Засгийн газрын гишүүдэд ойлгуулж байна лээ. Нэг тонн улаан буудайг 700 мянган төгрөгөөр аваад 2 сая 800-гаар гурилаа зардаг гээд. Өнгөрсөн жил нэг тонн улаан буудай 1 саяас 1 сая 200 байсан. Хамгийн бага 4 дүгээр зэргийн улаан буудай 920 байсан юм. Энийг одоо энд сууж байгаа манай Байнгын хорооны гишүүд мэдэж байгаа. Өнөөдөр 1кг гурил 1 дүгээр гурилаар би ярьж байна. 1 сая 900-аас 2 сая 100-гийн хооронд үйлдвэр үйлдвэрээсээ шалтгаалаад ийм үнэтэй байгаа юм байна лээ.

Гэхдээ гурилын үйлдвэрүүдийн дундаж ашиг энэ 2023 оны мэдээлэл байна. Татварын албаны мэдээлэл байна л даа ердөө 5 хувь. Инфляц ямар байгаа билээ. Гэтэл энэ банк санхүү уурхай, энэ цементийн үйлдвэр маш өндөр хувиар уул уурхай ялангуяа 50, 60 хувийн өндөр ашигтай ийм байгаа. Гурилын үйлдвэр газар тариалан 2-ыг салгаж ойлгож ердөө болохгүй. Еэвэнгийн 2 тал гэгчээр байна. Аль алийгаа дэмжиж нөхөж явж байдаг гэж хэлье. Гаалийн импортын татвар бол 15 хувь байгаа гурил дээр, тийм. НӨАТ байхгүй гурил дээр.

Тийм учраас гурилын үйлдвэрүүд 2 тайлан гаргах энэ тэр асуудал байхгүй л дээ. Яг л бодитой тайлангаа гаргадаг

гэдгийг хэлье. Ер нь одоо нэг 10 гаран жилийн өмнө 20, 30-аад гурилын үйлдвэр байсан. Өнөөдөр яг ажиллаж байгаа нь 9, 10 гурилын үйлдвэр үлдсэн. Нүүдэлчин групп гээд Эрдэнэтийн том үйлдвэр 150 тонныг хоногт хийдэг. Ажиллахгүй зогсож байна банканд бариатай, Дарханы гурил тэжээл, Ургац, гурилын үйлдвэр, Өсөх гурилын үйлдвэр гээд 5 жилийн өмнө байгуулагдсан ашигтай гээд л орсон. Өнөөдөр хаалгаа бариад банканд барьцаанд ийм л байгаа.

Ер нь тэгээд гурил улаан буудай энэ тэр стратегийн хүнс шүү. Стратегийн хүнсээ бас хамаагүй бодлогогүй алдвал тэгээд бид нар хамгийн түрүүнд идэх хоол хүнсээрээ гаднын хараат болж аманд нь багтах л юм болно шүү дээ. Энийг бол Ерөнхий сайд Баяр Ерөнхий сайд байхдаа хатуу ойлгосон. 100 мянган тонн гурил будаа гуйж очоод Засгийн газрын хоорондын комиссын хурал дээр бүх юманд Оросуудын аманд багтсан. Хоолоо гуйж хүнтэй харьцана гэдэг чинь энэ үнэхээр байж болохгүй зүйл юм байна гээд Атрын 3 дугаар аяныг эхлүүлсэн, хийсэн. Тэрний хүчинд бас жил жилдээ Монгол Улс 70-аас 100 хувь гурил будаагаар хангадаг болсон юм. Хэрвээ хэмжээ хязгааргүй гурил будаа оруулаад байвал энэ байдал бол эргээд ухралт руугаа очих нь ойлгомжтой. Тэгэхдээ манай ХХААХҮЯ-аас бол энэ гурилын тодорхой хугацаагаар 7 сарын 1 хүртэл одоо 12 мянган тонн гурилыг баруун аймгуудаар оруулаад эхэлчихсэн байгаа, дахиад 25 мянган тонныг бусад боомтуудаар оруулъя гэсэн ийм саналыг өгсөн юм гэдгийг бас хэлье ээ.

Г.Тэмүүлэн: Анандбазар гишүүн нэмж тодруулах уу? Анандбазар гишүүнд микрофон нэмж өгье.

Ц.Анандбазар: Амарбаясгалан дарга аа энэ гурилын үйлдвэр дээр ганцхан юм байна та бас тэмдэглээд аваарай. Бизнесийн салбарт байсан учраас би алдааг нь олж харлаа. Гурилын үйлдвэрийн алдаа юу байсан гэхээр НӨАТ-

ыг 0 болгоод, гаалийн татварыг 15 хувь болгосон юм байна. Ямар ч бизнес зөрөөтэй татвар тавьж болдоггүй юм аа. Та саналаа оруулахдаа гаалийн татварыг 5 хувь болгоод НӨАТ-ыг татварыг 10 хувь болгочих. Ингээд л гурилын хэрүүл Монгол Улсад дуусна аа. Тэглэж байгаа нь бүх бизнесийг унагааж байгаа юм шүү. Би гишүүн болоод ер нь олон удаа НӨАТ, гааль тэглэж байна. Тэгээд ямар толгойтой хүний санаанд ийм юм ороод байдаг юм. Би бүүр гайхаад байдаг юм. Ямар ч бизнес ижил нөхцөлөөс явж байж л тогтдог. Энэ амьдралын хууль байгаа юм.

Тэгэхээр та энийг нэг сайн судлаад хэрвээ хэрэгтэй бол би бас тантай уулзъя гэж бодож байна. 2 дахь нь танд бас хамтраад энэ сайхан санал санаачилгыг дэмжиж Монгол Улсад 7 тэжээлийн аж ахуй байгуулах хэрэгтэй байна аа. Энэ төслийг та нэг танилцаад.

Г.Тэмүүлэн: Амарбаясгалан дарга, 5 номер.

Д.Амарбаясгалан: Мэдээж татвартай холбоотойгоор зөв тэнцвэрийг олох гэдэг бол чухал асуудал байгаа юм. Гэхдээ одоо бид стратегийн хүнс гэдэг байдлаар импортын татвараа өндөр тавьчхаад эргээд ард иргэдэд дэлхийн зах зээлээс 3 дахин өндөр үнэтэй гурил хэрэглүүлж байгаа байдал бол төрийн шийдвэр бодлого зохио зохих түвшиндээ хүрч үр дүнгээ өгөхгүй байгаагаа илэрхийллээ гэж ингэж харж байгаа юм. Өнөөдөр хил дээрх 1 дүгээр гурил 1кг нь 935 төгрөгөөр орж ирж байгаа юм. Гэтэл Монгол Улсад борлуулагдаж байгаа үнэ нь 2600-аас 3 мянган төгрөгөөр борлуулагдаж байгаа юм. Импортын гурил 50 кг-ынх нь шуудайтай гурил импортоор одоо жишээ нь Увс аймгийн Улаангом хотод 80 мянган төгрөгөөр зарагдаж байхад манай дотоодод үйлдвэрлэсэн 1 дүгээр гурил 140 мянган төгрөгөөр зарагдаж байх жишээтэй байгаа юм.

Тэгэхээр энийг зөв зохистой тэнцвэрийг нь олох чиглэл дээр Засгийн газар анхаарч ажиллана. Тэжээлийн үйлдвэр байгуулах асуудал.

Г.Тэмүүлэн: Баделхан гишүүн асуулт асууя.

Х.Баделхан: Баярлалаа. Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Өнөөдөр амьдрал шаардаж байгаа. Уг нь эртхэн чөлөөлсөн байвал бүүр сайн байсан. Гэхдээ одоо ч гэсэн гаалийн татвараас чөлөөлөхөд оройтохгүй. Бид нар сая хөдөө яваад иргэдтэй уулзсан. Малчидтай уулзаад ирсэн. Яг өнөөдрийн байдлаар бол малчдын байдал нэлээн хүнд байна. Ялангуяа төвөөс алслагдсан аймгууд дээр бол малын хаваржилтын зуд бол одоо эхэлнэ л дээ баруун аймгуудад.

Тийм учраас саяын ярьж байгаа малын тэжээл гурилын үнэ бол өндөр энэ асуудал маш их яригдсан. Төвөөс алслагдсан баруун аймгуудын хувьд бол 100 км очоод хил даваад хилээсээ хямдхан гурил тэжээл оруулж ирэх боломжтой. Гэтэл татвар тавьснаас болоод ингээд өндөр тэжээл гурил хэрэглэж байгаа л даа. Тийм учраас энэ асуудал дээр онцгой анхаараач гэж иргэд маш их хүсэлт тавьсан. Өнөөдөр ингээд хуулийн төслөө оруулж ирж байгаад баяртай байна аа. Ер нь өмнө ч гэсэн дандаа ер нь Оросын гурил Оросын өвс тэжээл хэрэглэдэг байсан л даа. Хямдхан. Сая Амарбаясгалан дарга хэллээ шүү дээ. Увсад бараг 2 дахин хямдхан үнэтэй байна, хямдхан байна гэж. Энэ манай аймагт ч гэсэн тийм байсан.

Тийм учраас энэ татвараас чөлөөлж байгааг бол дэмжиж байгаа. Харин ямар тооцоо байгаа юм бол? Одоо ингээд татвар чөлөөлөхөөр гурилын үнэ хэр буух вэ? Малын тэжээлийн үнэ ч гэсэн хэдэн хувиар буух вэ? Энэ талын тооцоогоо нарийн тооцоо байвал тооцоог нь сонсмоор байна.

Хоёрт бол ер нь цаашидаа жил болгон зутарна аа. Малын тэжээл дээр бол онцгой анхаарах нь зөв. Манай аймаг дээр Ногоон нуурын тэжээлийн аж ахуй гэж маш том тэжээлийн аж ахуй байсан. Бараг баруун 3 аймаг бол өвс тэжээлээр хангачихдаг байсан. Өнөөдөр бүгд тарчихсан юу ч байхгүй, зүгээр газар нь ингээд үлдсэн байгаа.

Тийм учраас Засгийн газраас ер нь малын тэжээлийг хангах асуудлаар цаашидаа бас тодорхой бодлогоо боловсруулж хөтөлбөр хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн ийм саналтай байна аа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: *Баделхан гишүүний асуултад хариулъя. Амарбаясгалан дарга, 5 номер.*

Д.Амарбаясгалан: *Тийм, малын тэжээл энэ цас зудын нөхцөл байдалтай холбогдуулаад ер нь бол хомсдол нэлээн бий болчихож. Яагаад гэхээр 2023 оны 11 дүгээр сараас эхлээд нийт улс орон даяар нийт газар нутгийн 80 хувь нь цасан бүрхүүлтэй болсон. Улмаар малчид эртнээс эхэлж малаа байнгын суурин байлгаж тэжээх ийм шаардлага үүссэн байгаа юм. Ингээд дагаад тэжээлийн хомсдол бодитой гарчхаж. Өнөөдөр жишээ нь 1кг хивэг тэжээлийн үйлдвэрлэлийн өртөг нь 200 орчим төгрөг байдаг. Яг малчдын хотонд очихоороо мянгаас 1100 төгрөг болоод оччихож байгаа. Тэгэхээр энэ нөхцөл байдал орлого багатай малчид даван туулахад үнэхээр хүндрэлтэй болчихжээ л гэж Засгийн газрын зүгээс үзэж байгаа. Тэр ч агуулгаараа Засгийн газар сая 2 удаа үнэ төлбөргүй тэжээл хүргэх ажлыг зохион байгуулж өгч байгаа юм. Тэрнээс өмнө улсын нөөцөөс 11 сарын сүүлээс эхлээд 50 хувийн хямдралтай өвс тэжээлийг хангалтыг хийж байсан. Энэ мөн л адил өвс тэжээлийн үнэ өсөхөөс урьдчилан сэргийлсэн арга хэмжээнүүд байсан. ингээд үндсэндээ малчид бол тэжээлээ дийлэхгүй хажуугаар нь өргөн хэрэглээний хамгийн чухал бүтээгдэхүүн болох*

гурилын үнийг дийлэхгүй ийм нөхцөл рүү орсон учраас импортыг тэглэх энэ шийдвэрийг бол Засгийн газар өнөөдөр ингээд Улсын Их Хуралд өргөн барьж, хуулийн төсөл болгож өргөн барьж явж байгаа.

Цаашидаа би түрүүнд хэллээ. Төр бол нэг бол бүрэн дэмждэг байх ёстой, нэг бол зах зээлийг бүрэн хамгаалдаг бизнесийг нь эрсдэлээс хамгаалдаг байх. Ийм л зарчим руу шилжих ёстой юм байгаа юм. Тэгэхгүй олон төрлийн хөнгөлөлттэй зээл өгдөг, давхар бизнес, зах зээлийг нь хамгаалдаг энэ 2 бодлого хамтдаа хэрэгжээд үр дүнг өгөхгүй байна аа. Тэгэхээр дэмжлэг үзүүлэх хэлбэр биш харин өрсөлдөөний зарчмаар үнэ тогтдог энэ боломжийг нь бий болгож өгөөд хэрвээ эрсдэл учирсан тохиолдолд энэ зах зээлийг нь хамгаалах нөхөх олговор олгодог тэр тогтолцоо боломжийг олон улсын жишигт нийцүүлж бид хийх нь зүйтэй гэж ингэж бол үзэж байгаа юм. Жишээ нь АНУ улаан буудайн доод үнийг өөрөө тогтоодог.

Хэрвээ үнэ тэр доод тогтоосон үнээс доошоо ороод ирэх юм бол эрсдэлийг төр нөхөх олговор хэлбэрээр шийдэж чаддаг энэ жишиг бол байна. Хамгийн олон хүн амтай Энэтхэг Улс хүртэл энэ жишигийг бол амжилттай хэрэгжүүлээд явж байна. Мөн дээрээс нь байгалийн давагдашгүй хүчин зүйл бол нөлөөллөөр эрсдэл учирсан тохиолдолд мөн адил энэ стратегийн ач холбогдол бүхий салбарыг бол дэмжиж авч явдаг энэ бодлого бол хэрэгжиж байгаа юм.

Нэг зүйлийг бас их сайн ойлгомоор байгаа юм гишүүд маань. Бид гурилын импортын татварыг тавиад гурилын үйлдвэрлэлийг багасгачихна гэж боддогоо л болих хэрэгтэй байгаа юм. Нэгэнт гурилын үйлдвэр байгуулагдаад энэ ард түмэн олон нийтийн стратегийн ач холбогдолтой хүнсний бүтээгдэхүүнээр хангана гэж зорьсон бизнесийнхэн заавал ч үгүй яагаад өрсөлдөөнийг хумиад өндөр үнэтэй гурилаа зарах бодлогыг бид

дэмжих ёстой юм бэ гэдэг дээр бид сайн бодох ёстой. Тэд яагаад дэлхийн зах зээлийн өрсөлдөөн дунд үнээ зохицуулаад ард иргэдийг таатай амьдрах орчин нөхцөлөөр хангахад оролцохгүй байгаа юм бэ гэдэг дээр бид бас асуудлыг ярих ёстой. Түүнээс хэсэг бүлэг бизнес эрхлэгчдийн эрх ашгийг салбарыг хамгаалах нэрийн доор ард иргэд дэлхийн зах зээлээс 2-оос 3 дахин өндөр гурил хэрэглэх энэ нөхцөлийг хэрхэвч дэмжиж болохгүй л гэдэг энэ зарчим дээр бид байгаа.

Г.Тэмүүлэн: Туваан гишүүн асуулт асууя. Туваан гишүүний микрофоныг өгье.

Ц.Туваан: Зудын нөхцөл байдлын талаар нэлээн ярьж байгаа. Тэгээд энэ зуд эсэргүүцэх байдлаар энэ арга хэмжээг оруулж ирж байгааг дэмжиж байна аа. Тэгээд өшөө ч зөндөө бодлогууд хэрэгтэй байна аа. Ганц энэ тэжээлийн үнийн гааль, НӨАТ-ыг чөлөөлөх, гурилын гааль, НӨАТ-ыг чөлөөлөхөөс илүү чухал асуудлууд зөндөө байна. Малчин түмэн өнөөдөр сөхөрч байна.

Хаврын хахир хавсаргатай урт шар дээлтэй хүн чинь дөнгөж л ирж байна. Одоо бол богийн үхэл хар болсон ч тэр хээлтээд адууны үхэл энэ тэр одоо л эхэлдэг юм. Онд орлоо гэж бодох цаг хугацаа яагаа ч үгүй байгаа.

Тэгэхээр өшөө олон том дорвитой асуудлуудыг малчин түмэн хүлээж байгаа шүү гэдгийг бас энэ даширамд хэлье. Тэгээд энэ тэжээл улаан буудай ярьж байна. Тэгэхээр энэ дээр энэ стратегийн хүнс гэдэг зүйлээ бас яримаар байгаа юм. Юу гэхлээр стратегийн хүнсэнд улаан буудай, улаан буудайн гурил хоёулаа ордог. Стратегийн хүнс гэдгийг миний хувьд ямар нэгэн хүндрэлтэй нөхцөл байдал үүсэхэд тэрүүгээр таслахгүй иргэдээ хүнсээр таслахгүй байх гэдэг энэ л зүйлийг нь ярьж байгаа болов уу гэж бодож байна. Тэгэхээр энэ гурилын импортыг нь гааль НӨАТ-ыг тэглэснээр дамжаад нөгөө талд нь ар талд нь байгаа

тариаланчдын эрх ашиг бол шууд орж ирж байгаа юм аа. Бид нар атрын 3, 4 дүгээр аян зөндөө л. мөнгө төгрөг гаргаад өчнөөн олон жил үзэж байж энэ чинь бид нар жилдээ нэг 70 мянган тонн улаан буудай авч байсан хар өдрүүд байгаа шүү манай газар тариалангийн салбарт.

Тэгэхээр одоо нэг юм яг дотоодын хэрэгцээгээ 100 хувь хангаад ирж байгаа цаг үед тариаланчдын эрх ашиг гэдэг юман дээр ер нь зайлиггүй ярих ёстой. Өнөөдөр бас нэг хувь заяаны шоглоом ч юм уу. Яг ингээд энэний дараагийн асуудал Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороон дээр хаврын тариалалт ярих гэж байна. Тариаланчид энэ жил бид нар улаан буудай тарьж яах юм бэ гэдэг асуудал ярьж байгаа. Энэ одоо юун дээр яригдах байх гэж бодож байна. Тэгэхээр энэ дээр энэ шийдвэрүүд чинь асуулт нь бол 25 мянган тонн юм уу эс үгүй бол энэ хязгааргүй юм уу? Энэ танилцуулга дээр 2 буруу нэг болохоор 25000, нэг болохоор хязгааргүй гээд ингээд орж ирээд байна. Энийгээ нэг тайлбарлаж өгөөч.

Хоёрдугаарт, энэ салбарын яам Засгийн газрын Хэрэг эрхлэх газар энэ тариаланч гурилын үйлдвэр одоо энэ бодлогын яам эд нараа уулзуулсан уу? Энэ шийдвэр гаргахдаа ер нь яг энэ асуудлаа нийлж ярьсан уу гэдэг ийм асуултыг бас асууя.

Тэгээд ер нь бол энэ Ерөнхийлөгчийн санаачилгаар хүнсний хангамж аюулгүй байдал гээд бид нар бас нэг ажил хэрэгжүүлээд тэр үед болохоор ингээд л бүх л хувийн хэвшлийнхэндээ зээл, хуулийг нь өгөөд л ингээд явсан. Манай Байнгын хороогоор ч гэсэн өмнөх шийдвэрүүд, өөрөөр хэлбэл улаан буудайн борлуулалтын үе болоод ирэхээр нөгөө хэдэн гурилын үйлдвэрүүддээ зээл өгч байгаад л нөгөө улаан буудайг ав гээд л шахдаг шүү дээ. Одоо тариаланчид борлуулалт байхгүй байна гээд л ингээд л ярьдаг. Тэгэхээр энэ энэ асуудлуудыг бас нэлээн балансыг нь барих байдалтайгаар хийхгүй бол нуухыг нь авах гээд нүдийг нь

сохлоод бас ингээд тариаланчдадаа том эрсдэлд оруулчихвал энэ хоолтой холбоотой асуудал шүү. Би ингэж бодож байна.

Тэгээд энэ стратегийн хүнсний асуудал ингээд ороод одоо тариаланчид улаан буудайн тариалалт буураад ирж байгаа энэ цаг үед өвлийн бензин шиг асуудал үүсвэл яах вэ? Нэг улсаас хамааралтай, одоо бензин хомсдоод бид нар баларсан шиг тариалалтаа бууруулаад, улаан буудай импортлоод ингээд явж байсан чинь энэ импорт дээр асуудал үүсвэл яах вэ гэдэг ийм асуудлыг бас давхар бодох ийм шаардлага байна. Тэгэхээр ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Туваан гишүүний асуултад хариулъя. Амарбаясгалан дарга 5 номер.

Д.Амарбаясгалан: Монгол Улс улаан буудайн гурилыг дэлхийн аль ч улс орноос импортлоод оруулаад ирэх боломжсоор бол бүрэн хангагдсан олон талт харилцаатай ийм улс гэдгийг бас хэлэх нь зүйтэй. Дан ганц нэг улсаас хамааралтай болгох гэж энэ асуудал дээр хандаж байгаа зүйл бол огтоос байхгүй. Мэдээж таныг бас ойлгож байна. Төв аймгаас сонгогдсон гишүүн, тариалан эрхэлдэг газар нутгийг төлөөлж байгаа гэдгээрээ бас тариалан эрхлэгчдийн эрх ашгийг хангах, хамгаалах чиглэл дээр дуугарах нь бол зүй ёсны хэрэг. Би түрүүн бас тайлбарлаж хэлсэн. Тариаланчдыг эрсдэлд орохоос хамгаалах энэ нөхцөлийг төр, ЗГ бүрдүүлж өгнө. Харин тариаланчдаа хамгаалж байгаа нэрийн дор ард иргэдийг өндөр үнэтэй гурилаар хангах бодлогыг дэмжихгүй. Энэ өөрөө зүй зохистой л байх ёстой. Нэгийг нь хамгаалаад, нөгөөг нь хохироодог энэ бодлого руу яавч алхаж болохгүй юм байна.

Дахиад хэлье. Төр нэг бол бүрэн дэмждэг байх ёстой, нэг бол бүтэн хамгаалж чаддаг л байх ёстой. Энэ 2-ыг хоёуланг нь хэрэгжүүлэх бодлого дээр хэт

их төвлөрснөөсөө болоод үр дүнгээ өгөхгүй. Харин үүний үр өгөөжөөр цөөн хэдхэн компани асар их хэмжээний орлого олдог болсон. Та Туваан гишүүн жилд хураасан тарианы нийт өртөг 200 орчим тэрбум төгрөг. Түүнээс үйлдвэрлээд зарагдаж борлуулагдаж байгаа гурилын зах зээлээс олж байгаа нийт дүн 1 их наяд төгрөг. 800 тэрбум төгрөгийн зөрөөтэй том бизнес энд яваад байна. Тэгэхэд бид тэнд тариалан эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалж байгаа гэдэг нэрийн доор цаана байгаа энэ зохисгүй зах зээлийг хамгаалах гэж суух бол зарчимгүй зүйл юм.

Тэгэхээр зөв хэлбэрт нь л оруулахын төлөө төр өөрөө ажиллах ёстой. Ялангуяа Улсын Их Хурлын гишүүд маань энэ импортын татварын тэглэхтэй холбоотой асуудал дээр бол ард иргэдийг төлөөлж сууж байгаагийн хувьд анхаарал хандуулж ажиллах нь зүйтэй байх л гэж ингэж хэлмээр байна.

Ер нь тэгээд төрийн шийдвэрээр давамгайл байдлыг олж авч бизнес хийдэг энэ салбар бас ганц гурилаар тогтохгүй байгаа шүү. Та бүхэн бүгдээрээ мэднэ. Гуравхан жилийн өмнө цементийн үнэ 1 тонн нь 240 мянган төгрөг байж байгаад гуравхан сарын дотор 740 мянган төгрөг хүртлээ өсөж байсныг та бид мартаагүй. Түүний үр дүнгээр 1м2 орон сууцын үнэ 3 сая төгрөгөөс өнөөдөр 5 сая төгрөг болоод өсчихсөн. Эргээд цементийн үнэ 300 мянга болоод буусан мөртөө барилгын метр квадрат талбайн үнэ буугаагүй л хэлбэрт орчихсон байна. Тэгэхээр энэ зүй зохисгүй байгаад байгаа зах зээл өрсөлдөөнд шилжиж, зах зээлийнхээ зарчмаар явах тэр нөхцөл боломжийг ЗГ бий болгож өгнө гэдгийг бас та бүхэндээ хэлье.

2 дахь зүйл, сөрөг нөлөөлөл. Энэ зудын сөрөг нөлөөлөл гэж зүйл бол ганц энэ жилээр зогсохгүй гэдэгтэй санал нэг байна. Цаашидаа дэлхийн цаг уурын энэ өөрчлөлтөөс жил болгон давтагдах ийм нөхцөл рүү орж байна. Тийм учраас малчдыг энэ цаг уурын өөрчлөлтөөс бий

болж байгаа зуд ган гачгаас даван гарах энэ сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг Засгийн газраас авч хэрэгжүүлнэ гэж байгаа юм. Өнөөдөр малчид маань жилийн 20-24 хувийн хүүтэй зээлээр амьдралаа залгуулж амьдарч байгаа юм. Яг МАА-г нь ярих юм бол бэлчээрийн МАА, бизнесээр ярих юм бол хамгийн ашиг муутай бизнес. Гэхдээ тийм өндөр хүүтэй мөнгөөр амьдарч байгаа энэ нөхцөл боломжийг бид бодитой болгож дэмжлэгийг үзүүлэх, цаашидаа мал аж ахуйн салбар маань илүү төрөлжих, хагас эрчимжсэн байдлаар орох, өвс тэжээлээ өөрсдөө бэлтгэдэг болох тэр боломжийг бүрдүүлэх чиглэл дээр Засгийн газраас шат дараатай арга хэмжээг авч ажиллана.

Г.Тэмүүлэн: Туваан гишүүн нэмж тодруулъя. 1 минут.

Ц.Туваан: 25 мянган тонн уу, тэр хүмүүстэй нийлж уулзсан уу гэдэг асуулт дээр тодорхой хариулт авъя. Тэр малчны зээлтэй холбоотой малчдын зээлийг тэглэе гэдэг энэ санаачилгыг Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс гаргаад явж байгаа. Тэгэхээр яах вэ, нийтдээ 1.3 их наяд юм байна лээ. Тэгэхээр бид нар үүнийг бүгдийг нь мал нь хорогдоогүй эрсдэл гараагүй газруудын юмыг хамруулж яриагүй ээ. Одоо сая өнөөдөр би нэг зүйлд баярлаж байна. Энэ бодитой тоо ярьж байна. 20 сая толгой мал буюу Монгол Улсын нийт малын гуравны нэг 20 мянган өрхийн асуудал яригдаж байна. Энэ бодитой шүү. Тэгэхээр энэ дээр урьдчилсан байдлаар хэдүүлээ сая Баделхан гишүүн хэлж байна шүү дээ, урьд нь авах байсан юм гээд. Одоо урьдчилсан байдлаар хэдүүлээ энэ эрсдэл гарсан газруудаасаа тооллогоо дахиж явуулаад, бодитой гарсан эрсдэл дээр “малжуулах хөтөлбөр”-ийг нэлээн өргөн хүрээнд хийх ийм шаардлага байгаа юм. Тэгэхээр энэ дээр бас яг 3Г сая малчны зээлтэй холбоотой юм ярьсан учраас тодруулаад асууя.

Г.Тэмүүлэн: Туваан гишүүний асуултад хариулъя. Амарбаясгалан дарга 5 номер.

Д.Амарбаясгалан: Тариаланчдын төлөөлөлтэй хэсэгчилж Засгийн газраас уулзалт хийж байгаа. Тариаланчид ер нь бол 2 янзын байр суурьтай байгаа. Нэг хэсэг нь маш хямдхан үнээр улаан буудайгаа зардаг. Бид ер нь зах зээл дээр чөлөөт өрсөлдөөнд орох боломж бол байдаггүй. Яагаад гэвэл гурилын үйлдвэрүүдийн дарамтад бизнесээ хийж байна гэдэг зүйлийг бол маш ихээр ярьж байгаа. Гурил үйлдвэрлэгч нар 700 төгрөгөөр авсан килограмм буудайг 3000 төгрөг хүргэж гурил болгож зарж байж, яг бидний тарьсан хурааж авсан улаан буудайг бүрэн авдаггүй ээ. Ер нь бол нэг 40 орчим хувийн хаягдалтай хэлбэрээр авдаг. Тэгжээл рүү 40 хувийг нь явуулдаг гэдэг нэг ийм нөхцөл бол үүссэн байна лээ. Тэгэхээр тариаланчдын хувьд бол зах зээлийг шударга болгох тал дээр нэг хэсэг нь бол байна.

Нөгөө хэсэг нь мэдээж хэрэг энэ салбар уналтад орох вий, эрсдэлд учрах вий, цаашидаа улаан буудай тарих уу, үгүй юү гэдэг асуудал дээр бол ярьж байгаа ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Амарбаясгалан дарга 1 минут нэмээд тайлбараа гүйцээе.

Д.Амарбаясгалан: Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас 25 мянган тонныг импортын татваргүйгээр оруулж ирэх саналыг ирүүлсэн, Засгийн газарт. Засгийн газраас шийдвэр гаргахдаа хэмжээ, хугацаа тавихгүйгээр шийдвэрлэх нь зүйтэй гэсэн байдлаар шийдвэр гарсан байгаа.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүн асуулт асууя.

Д.Өнөрболор: Энэ яаралтай горимоор энэ хуулийн төсөл орж ирж байгаа юм байна. Тэгээд хаваржилтыг ер нь даван туулахад шаардлагатай 100-200

мянган тонн өвс, 385-412 мянган тонн нэмэгдэл тэжээл шаардлагатай. Үүнээс 70, 80 хувийг нь бол импортоор оруулж ирнэ гэж байгаа юм байна. 10 орчим гурилын хувь 25 мянган тонныг импортоор гаалийн татвараас чөлөөлөх ийм хуулийн төсөл орж ирж байна гэж ойлгож байна. Тэгэхээр 1 хэд хэдэн зүйл тодруулах хэрэгтэй байна.

Энэ чөлөөлөлтөд ер нь хэдий хэмжээний яг дүн тооцоо гарч байгаа вэ? Энэ импортын өвс тэжээл, гурил, зах зээл дээрх ер нь яг үнэ яг хэд байгаад, энэ жилийн тариалалтад ер нь энэ импортоор оруулж ирж байгаа бараа бүтээгдэхүүн тариалалтад нөлөөлөх үү?

Нөгөөтээгүүр энэ малчдын зээлийг хойшлуулж байгаатай холбоотойгоор Төрийн банкны зээлийг хойшлуулж байна. Хаан банкны зээлийг хойшлуулахгүй ийм мэдээтэй байгаад байна. Тэгээд малчид бас энэ дээр нэлээн их асууж байна л даа. 1.3 их наяд төгрөгийн зээл бол ойролцоогоор 50, 50 хувийн байгаа юм байна лээ гэж би ойлгосон. Энэ Төрийн банк, Хаан банк дээр. Тэгэхээр Хаан банк яг энэ зохицуулалтад яг яаж оролцож байгаа вэ гэдгийг бас асууя.

Нөгөөтээгүүр энэ шатахууны хомсдол, эрчим хүчний хязгаарлалт, энэ зуд турхан гэдэг бол ер нь манай улсад өнөөдөр тохиолдоод байгаа зүйл бас биш ээ. Яах вэ, өнөөдөр Засгийн газраас бас тийм дэмжлэг, туслалцаа хэр чинээгээрээ л хичээгээд, асуудлуудыг шийдвэрлээд ингээд явж байгааг ойлгож байна. Гэхдээ дараа жил, түүний дараа жил ч гэсэн ийм эрсдэлүүд бол үүссээр л байх болно оо. Тэгээд би энэ Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам нэн ялангуяа зүгээр энгийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож байгаа энэ зохицуулалт төлөвлөлтийг бол ойлгож байгаа болов чиг энэ эрсдэлийн үеийн энэ менежмент төлөвлөлтийг ер нь та нар яг юу гэж үзэж байгаа вэ? Тухайлах юм бол бид нар яг газар дээр нь ингээд орон нутагт ажиллаад, малчидтай бас ингээд

уулзаж байгаа байхгүй юу. Тэгэхэд сум орон нутгийн нөөц, өвс тэжээлийн хомсдолын асуудал аягүй ноцтой байгаа байхгүй юу. Тухайлах юм бол 80, 90 хувь нь 3 сарын эхээр гээд тэгэхэд бараг дуусаж байна. Засгийн газраас хангаж байгаа хангамж ч гэсэн ерөнхийдөө дуусаж байна.

Тэгээд би Амарбаясгалан даргад бас энэ эрсдэлийн менежментийн асуудлыг бас нэн ялангуяа цаашидаа бол бас анхаарч энэ төлөвлөлтийг урьдчилж харж хийж байхгүй бол ийм асуудал байнгын байна. Тэгээд хэдий болгон үүнийг ингээд ийм нөхцөл байдалдаа ингээд л тааруулаад аргацаасан байдлаар асуудал шийдэх вэ гэдгийг бол бас энэ дээр танд энийг анхаарах нь зүйтэй байх гэж хэлмээр байна.

Тэгээд нэн ялангуяа энэ оролцогч талууд тийм ээ, тухайлах юм бол үндэсний үйлдвэрлэгчид, тариаланчид, малчид тийм ээ, тэгээд энэ төр, хувийн хэвшил, тэдний оролцоо, гүйцэтгэх ажил үүргийг бол төр маш тодорхой болгож өгмөөр байна. Ингэж тодорхой болгож өгөөгүйгээс болоод өнөөдөр төр хийх гээд ч байгаа юм шиг төр энийг зохицуулах гээд ч байгаа юм шиг. Тэгээд энэ асуудлууд улам их эрсдэж ингэж даамжрах нөхцөл байдал үүсэж байна гэж харагдаж байна. Нэгэнт эрсдэл яригдаж байгаа үед бол бас энэ малын индексжүүлсэн даатгалыг боловсронгуй болгох шаардлагатай юм байна гэж үзэж байгаа. Миний бие болон бас энэ манай Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны нэлээдгүй гишүүд бас оролцсон. Энэ хуулийн хэрэгжилтийг хянан шалгах ажлын хэсгийг миний бие ахалж ажиллаж байгаа. Энэ дээр тухайлах юм бол малчдын эрсдэлийг бууруулах, малчдын эрсдэл даах чадварыг нь нэмэгдүүлэх чиглэлд эрх зүйн орчныг бас боловсронгуй болгох хэрэгтэй юм байна. Гамшигийн үед эрсдэл хуваарилагдах ийм механизмыг бол төр өнөөдөр маш төлөвлөлттэй, зохион байгуулалттай

хийхгүй бол болохгүй юм байна гэдэг нь өнөөдрийн энэ ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүний асуултад Амарбаясгалан дарга 5 номер.

Д.Амарбаясгалан: Энэ тэжээл, гурилын үнэ бол би түрүүн бас хэлсэн байгаа. Дэлхийн зах зээлтэй харьцуулахад өндөр үнэтэй байна. Улаан буудай бол дэлхийн зах зээлийн ханшаас төдийлөн хол зөрөөтэй байхгүй байгаад байгаа юм. Гол нь улаан буудайгаар үйлдвэрлэгдсэн гурил маань дэлхийн зах зээлийнхээ ханшаас 2-3 дахин өндөр байгаа ийм нөхцөл дээр очсон байна.

Мөн тэжээлийн асуудал байна. ОХУ-аас импортлогдож орж ирж байгаа тэжээл, 25 кг-ын шуудайтай хивэг 14-15 мянган төгрөгийн үнэтэй байхад өнөөдөр малчны хотонд очиж байгаа хивэг тэжээл 25-30 мянган төгрөг болж очиж байгаа. Тэгэхээр энэ нөхцөлийг л бид арилгах бол зүйн хэрэг юм аа. Мэдээж бизнес хийж ашиг олохыг эсэргүүцэж байгаа зүйл биш. Харин зах зээл дээр импортын татвар тавиулаад хомсдолыг үүсгээд монопол тогтоож ажиллаж байгаа энэ зүйлийг арилгаж, өрсөлдөөнийг бий болгох зорилгыг агуулж байгаа.

Малчдын зээлийн асуудал дээр ЗГ бол бас анхаарал хандуулж ажиллаад Монголбанктай хамтарч ажиллаж байгаа. Монголбанкны зүгээс өнгөрсөн 7 хоногийн Пүрэв гарагт Хаан банк, Төрийн банк, арилжааны банкнуудтай уулзалт хийгээд зээлийн эргэн төлөлтийн үндсэн зээлийн эргэн төлөлтийн хугацааг бол хойшлуулсан ийм шийдвэр ойлголцолд бол хүрсэн байгаа. Засгийн газраас малчдын зээлийн хүүг хойшилж байгаатай холбоотойгоор хүүгийн хуримтлал үүсэх нөхцөлөөс урьдчилан сэргийлэхээр арга хэмжээг бол авч ажиллаж байна. Энэтэй холбоотойгоор дэлгэрэнгүй мэдээллийг Сангийн сайд өгнө өө гэж ингэж ойлгож байна.

Эрсдэлийн менежментийн асуудал яригдаж байна. Ер нь энэ цаас зудын нөхцөл байдалд мэдээж ЗГ цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан бэлтгэл хангаж ажиллаж байгаа. Нэг талаасаа яг малын асуудал өөрөө малчны хувийн өмч хэлбэрээр явдаг. Мал аж ахуйн салбарыг эрсдэлгүй байлгах чиглэл дээр мэдээж төр бодлого гаргаж ажиллаж ирсэн. Олон жилийнхээ дундаж, олон жилийн туршилага дээр үндэслээд энэ өвс тэжээлийн нөөцийг бэлтгэх, малчдыг эрсдэлгүй өвлийг, хаврыг даван гарахтай холбоотой бодлого бол хэрэгжиж ирсэн. Зүгээр энэ 2023-аас 24 онд шилжих өвөл, хаврын нөхцөл бол энэ цаас зудын байдал урьд урьдын жилүүдтэй харьцуулахад 3 дахин их хэмжээний нөлөөллийг үзүүлж байгаа байдал нь цаашидаа энэ мал аж ахуйн салбарт онцгой анхаарал хандуулах хэрэгтэй юм байна. Зөвхөн бэлчээрийн байдлаар МАА маань дангаараа оршин тогтноход энэ байгалийн сөрөг нөлөөлд бол тэсвэрлэхэд хүнд болж байгаа юм байна. Тийм учраас шат дараалсан урт хугацааны бодлогыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж ингэж Засгийн газрын зүгээс үзэж байгаа.

Энд нэг л зүйл байгаа юм. Би түрүүн энэ зээлтэй холбоотой асуудал дээр бас тайлбар хийж байсан. Малчдын зээл өнөөдөр яг чанараараа арилжааны банк талаас харах юм бол хамгийн найдвартай зээлийн нэг байгаад байгаа юм. 1 дүгээрт ордог зээл нь ипотекийн зээлийн үнэлгээ байдаг бол 2 дугаарт малчны зээл өөрөө эргэн төлөлттэй нь их сайн байдаг гэдэг үзүүлэлттэй. Гэхдээ малчид маань маш өндөр хүүтэй зээлээр амьдарч байгаа ийм нөхцөл дээр оччихож. 20-24 хувийн хүүтэй байна. Тэгэхээр энэ өндөр хүүтэй, богино хугацааны зээлээр биш, бага хүүтэй, урт хугацааны зээлээр өөрийнхөө МАА эрхлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх дээр ЗГ бодлого, хөтөлбөр гаргах нь зүйтэй гэж ингэж үзэж байна.

Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу Монголбанк, Зээлийн батлан

даалтын сан, Давхар даатгал, Арилжааны банк, хувийн даатгалын байгууллагуудтай хамтарсан ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Тэгээд энэ талаар тун удахгүй Улсын Их Хуралд бодлогоо танилцуулна гэж хэлье.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүн нэмж тодруулах уу? Сангийн сайд хүүтэй холбоотой, хүүгийн хуримтлал үүсгэх эрсдэлтэй холбоотой гэсэн асуулт асуусан байгаа. Жавхлан сайдын микрофоныг өгье, 1 минут.

Б.Жавхлан: Асуултад нэмж хариулъя. Сая Амарбаясгалан сайд бараг хариулчихлаа даа. Энэ аливаа зээлийн хувьд нэг ийм ойлголт байгаа шүү. Бүх зээлийг бид нар тэглэж болохгүй, чадах ч үгүй. Тэглэнэ гэдгийн цаана энэ чинь татвар төлөгчдийн мөнгө байгаа. Энэ банкны өөрийнх нь эрсдэл байхгүй юу. Банкны эрсдэл. Нэг зээлдэгч нь муудахаар банк эрсдэлээ хүлээх ёстой юм байгаа юм. Банкны өмнүүр орж банкны эздийн эрсдэлийг нь хааж татвар төлөгчдийн мөнгөөр зээлийг нь тэглэнэ гэдэг ойлголт байж болохгүй. Энийг хатуу хэлье. Харин эрсдэлд орсон малчдын маань асуудал тусдаа асуудал. Амьжиргааны эх үүсвэрээ алдсан энэ чинь Монгол Улсын иргэд. Энэ дээр төр анхаарлаа хандуулж энэ дээр халамжийн бодлого, малжуулах, амьжиргааных нь эх үүсвэр дээр нь бид төрөөс тусламж, дэмжлэг үзүүлэх, халамжаас хөдөлмөр лүү шилжүүлэх, хөдөлмөр эрхлэх гээд энэ бүх бодлого энэ дээрээ төвлөрөх ёстой. Энэ бол тусдаа асуудал. Банк эрсдэлээ хүлээе, төр эрсдэлээ ч бас хүлээнэ. Төрийн эрсдэл бол амьжиргаагаа алдсан иргэдийнхээ амьжиргааг нь сайжруулах энэ бодлого руугаа бид төвлөрөх ёстой. Тэрний нэг хэсэг нь зээлээ эргэн төлөх, төлбөрийн чадваргүй болсон малчин, мал бүхий иргэддээ тодорхой хэмжээнд нь төр оролцож энэ дээр дэмжлэг үзүүлнэ. Энэ дээр маш тодорхой шийдвэр гаргачихсан байгаа шүү дээ.

Энэ байгалийн гамшиг. Энэ бүр гамшиг болсон шүү. Энэ зүй бус хорогдол биш. Энэ бүр гамшиг болсон. Гамшигийн босго нь 6 хувийн хорогдол байдаг бол аль хэдийн зарим аймгууд бүр 40, 50 хувиар даваад явчихсан байна. Энэ дээр төр ажиллах ёстой. Тийм учраас энэ банкны зээл гэдэг энэ хоморгон дотор өөр асуудлыг шийдэж ингэж бид болохгүй ээ. Төр ажиллах ёстой, эргэж харах ёстой, халамжлах ёстой, дэмжлэг үзүүлэх ёстой энэ иргэддээ бодлого төвлөрөөд ингээд явна.

Энэ жилийн хувьд зээлийг хугацааг нь хойшлуулах бол наад захын асуудал, наад захын асуудал шүү. Мэдээж төр гэдэг утгаараа Төрийн банк бол энэ бодлогоо дагаад явна. Хувийн хэвшлийн банкнууд дээр бид уриалж байгаа.

Дээрээс нь Монголбанк хэдхэн хоногийн өмнө шийдвэр гаргасан нь юу вэ гэхээр банкнуудын зээлийн ангилал, өөрөөр хэлбэл хар жагсаалтад оруулахгүй байх талаар энэ дээр нэн хөнгөлөлттэй ийм шийдвэрүүд гаргасан байгаа. Энэ хугацаанд нь төр малчдадаа амьсгаа өгөх, боломж өгөх, хүү дээр нь хөнгөлөлт үзүүлэх, малчдын зээл энэ иргэний зээл гэдгээрээ нэлээн өндөр хүүтэй байдаг. 20, 21 хувийн хүүтэй. Энэ дээр нь бусад хөнгөлөлттэй зээлүүдийн түвшинээр 6 хувийн энэ хүүгээс нь бусад давсан хүүгийнх нь энэ зөрөөг нь төрөөс дааж хөнгөлөх ийм бодлого шийдвэрээ ЗГ маш тодорхой гаргасан байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Мөнхцэцэг гишүүн асуулт асууя.

Г.Мөнхцэцэг: Гаалийн албан татвараас чөлөөлөх энэ хуулийн төслийг дэмжиж байна. Тэгэхээр ер нь Монгол Улс нэлэнхийдээ ер нь хагас 100 жил болоогүй шахуу ийм зудын хүнд байдалд орлоо. Тэр тусмаа говийн тал хээрийн бүс нутаг ерөнхийдөө нэлдээ ийм гамшигийн байдалд хүрчихсэн. Монгол Улсын Засгийн газраас ч тодорхой хэмжээгээр тодорхой тухай үед шуурхай арга хэмжээ авч

байсныг бас малчид түмэн маань бас өнөөдөр бас ярьж л байна. Гэхдээ ер нь ингээд 6 сая гаруй толгой мал устчихсан байж байна, хорогдчихсон байж байна. 20 гаруй мянган малчин өрх ер нь малгүй болчихлоо гээд ингээд энэ тоо баримтуудыг энэ мэдээллээс ингээд аваад харж байна л даа.

Тэгэхээр бид нар одоо яг яах вэ, гаалийн татвараас чөлөөлөхөөр өнөөдөр яах вэ, энэ салбарт үйл ажиллагаа явуулдаг ч гэдэг юм уу, яг ийм үйл ажиллагаа явуулдаг ААН-үүд оруулж ирэх байх, тийм ээ. Тэгэхээр ер нь Монгол Улсын Засгийн газраас өөрөө бас тодорхой нөөц сангаасаа зардал гаргаад ч гэдэг юм уу энэ өвс тэжээл оруулж ирэх тал дээр анхаарах юм уу? Ер нь ямар хэмжээний судалгаа хийгээд байна. Хэдий хэмжээний ийм өвс тэжээлүүд оруулж ирж байж энэ бас нөхцөл байдлыг өнөөдөр бас жоохон эрсдэлүүдийг бууруулах вэ гэдэг ийм судалгаа тандалт хийсэн зүйл байна уу гэж.

2 дугаарт гэвэл өнөөдөр говийн нөхцөлд хавар нь илүү хүнд болдог. Өвөлжилтөөсөө илүү хаваржилт илүү хүндэрнэ гэсэн ийм байдалтай байж байна. Энэ олон толгой мал хорогдсон, говийн бүсэд нэлээдгүй хэмжээний мал толгой мал хорогдсон. Тэгэхээр малчин өрхүүд маань юу гэж байна гэхээр бид нарт нэг хэсэг цасанд дарагдаад ингээд хэцүү байсан. Одоо ингээд үхсэн малаа бас зөөж тээвэрлэх, халдваргүйжүүлэлт явуулах ингээд энийгээ устгах гэдэг ажил дээр бид нар үнэхээр хүн хүчний үнэхээр хомсдолд ороод байна. Тодорхой хэмжээний бензин шатахуун гээд ингээд ийм эрсдэл үүсээд бид хэд энэ ийм хүнд байдалтай байж байна гэдэг зүйлүүдийг бас ярьж байна л даа. Тэгээд ирэхээр энэ малын халдваргүйжүүлэлтийг хийх, дээрээс нь бас энэ устгалыг хийх гээд ингээд ийм тодорхой хэмжээгээр ийм бүсчилсэн зүйлүүдийг Засгийн газраас авч хэрэгжүүлэх үү, хийх үү. Тодорхой хэмжээний шатахууны гэдэг юм уу ямар нэгэн дэмжлэг туслалцаануудыг үзүүлэх

үү. Энэ дээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэж байна вэ гэдэг ийм зүйлүүдийг бас малчин өрхүүд маань бас асууж ингэж сануулж байна. Тэгээд энэ дээр үйл ажиллагаа юу явуулж байна вэ гэдэг зүйлийн асуултыг тавьж байна.

Г.Тэмүүлэн: Амарбаясгалан дарга асуултад хариулъя. 5 номер.

Д.Амарбаясгалан: Зудын эрсдэлд 20 орчим сая мал хорогдох аюултай гэж ингэж бол үзэж байгаа. Өнөөдрийн байдлаар 5 орчим сая мал хорогдсон ийм дүн мэдээтэй байгаа. Үүний нөлөөгөөр бас 20 гаруй мянган малчин өрх амьжиргаагаа залгуулах малгүй болох нь. Энийг ЗГ бууруулахын төлөө ажиллана гэж ингэж бол алхам хийж байна.

Яг малчид маань юу юугүй Засгийн газрыг үнэ төлбөргүй өвс тэжээл авчраад өгөөч гэж шаардахгүй байгаа. Гол нь зах зээлийн бодит ханшаар өвс тэжээл, гурил худалдан авах боломжийг бий болгож өгөөч гэж. Зуд болохоор чоно зоолдогтой адилхан амьдрал тааруу, худалдан авах чадвар муудаж байгаа цаг үед нэн шаардлагатай байгаа өргөн хэрэглээний гурил, малын өвс, тэжээл хэд дахин үнэ өсөж байна гэдэг асуудал яригдаж байна. Өнөөдөр 3 хониор нэг шүүдэй 50 кг гурил авах хэмжээнд хүрсэн байна. Нэг хониор нэг боодол өвс авах хэмжээнд хүрч байгаа юм. Тэгэхээр энэ өөрөө бодит зах зээл биш байна, өрсөлдөөнийг бий болгож өгөөч л гэдэг асуудлыг хийж байна. Тэгэхээр Засгийн газрын зүгээс импортын татварыг тэглэх, зах зээл дээр өрсөлдөөнийг бий болгох зорилгоор энэ шийдвэрийг гаргаж байгаа.

Цаашидаа бид импортын татвар тавьж, хориглолтыг хийдэг, зах зээл дээр монопол үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг энэ бодлогоосоо ЗГ татгалзах нь зүйтэй гэж үзэж байна. Харин түрүүн хэлсэн тариалан эрхлэгчдийг стратегийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, тарьж ургуулж байгаа нөхцөлийг нь хамгаалах чиглэл дээр бол ЗГ бодлого гаргах ёстой.

Нэг ёсондоо гурил үйлдвэрлэгч нарыг хэт их давраахгүй, тариалан эрхлэгчдийг хохироохгүй байх энэ бодлого дээр ЗГ ажиглаж байна.

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулах уу? Мөнхцэцэг гишүүн. Мөнхцэцэг гишүүн.

Г.Тэмүүлэн: Тэр нөгөө хоргодсон малын сэг зэмийг устгах, тийм ээ, ариутгах ийм үйл ажиллагаануудыг хэдийнээс эхлүүлж явуулах юм? Ер нь малчин өрх өөрсдөө сая тэгж байна шүү дээ. Цасанд дарагдахаасаа илүүгээр бид нар энэ хоргодсон малынхаа энэ сэг зэмэнд дарагдаад энийгээ бас холдуулах барих гээд зөндөө олон ажлууд бидэнд бас байна. Тэгээд ер нь хаваржилт яагаа ч үгүй байна шүү дээ гэдэг зүйлүүдийг бас ярьж байна л даа. Тэгэхээр энэ дээр Засгийн газраас тэр тусмаа ХААЯ ер нь ямаршуухан үйл ажиллагаануудыг явуулж байгаа юм? Тийм ээ, энэ дээр хариулт авъя.

Г.Тэмүүлэн: Болорчулуун сайд хариулах уу? Болорчулуун сайд.

Х.Болорчулуун: Энэ жил ойрын жилүүдэд байгаагүй мал хорогдлоо. Тийм учраас маш их сэг зэм энд тэнд аймаг сумдад үүссэн. Энэ нь бол халдварт өвчин тараах, янз бүрийн бохирдол үүсэх ийм нөхцөл байдлыг үүсгэх нь ойлгомжтой. Тийм учраас энэ асуудлыг цэгцлэх сэг, зэмийг арилгах үүднээс ирэх 7 хоногт Засгийн газрын хурлаар бол манай яамнаас асуудлыг оруулна. Засгийн газрын тогтоол мэдээж гарч таараа. Ер нь тэгээд энэ ажилд гэхэд л 10 гаруй тэрбум зарцуулахаар ерөнхий тооцоо гарч билээ гэдгийг бас хэлье.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн гишүүн асуулт асууя. Чойжилсүрэн гишүүн.

Б.Чойжилсүрэн: Урьд нь гишүүд асуучихлаа. Дахиад асуухаас. Энэ хавраас эхлээд нөгөө малчид юу тариаланчид маань улаан буудай тарихгүй гэдэг асуудал нээрээ ерөнхийдөө бас юу нэлээн

газар авч яригдаад байгаа юм байна лээ. Тэгэхээр Болорчулуун сайд энэ ирэх жилийн зах зээл чинь их төвөгтэй, удирдахад хэцүү байдалд орох юм биш биз дээ? Хугацаагүй гээд яаж байгаа юм байна шүү дээ.

2 дугаарт, тариалан эрхэлж байсан хүмүүс эрсдэлд ороход ямар хэмжээний дэмжлэг өгөх юм? Ямар хэмжээний татаас өгөх юм, урьдчилсан баримжаа байна уу? Тэгэхгүй бол энэ улаан буудайн тариалалт чинь хяналтгүй болох вий дээ. Бүр хүндрээд гурил чинь өөрөө стратегийн бүтээгдэхүүн шүү дээ, ямар ч үнээр хамаагүй авч идэх шаардлага байна шүү дээ.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн гишүүний асуултад хариулъя. Амарбаясгалан дарга 5 номер.

Д.Амарбаясгалан: Гурил стратегийн бүтээгдэхүүн мөн байгаа. Бас гурил бензин шиг ганцхан улсаас импортлох нөхцөлөөр бол шахагдаагүй байгаа, олон талаас бас энэ гурилыг импортлох нөхцөл дээр бол очиж байгаа. Тэгэхдээ би түрүүн тодорхой хариулсан байгаа.

1 дүгээрт, зах зээлийн бодит ханишнд гурил маань өөрөө хүрэх ёстой. Монголын ард иргэдийн худалдан авах чадвар дэлхийн хөгжилтэй улс орны түвшинд бол хараахан хүрээгүй. Гэхдээ өнөөдөр худалдаж авч байгаа гурилын үнэ тэдгээр улсынхаас 2-3 дахин өндөр үнэтэй байгаа нь энэ өөрөө зах зээл нь бодит өрсөлдөөний зарчмаар явахгүй байгааг илэрхийлж байгаа юм. Тийм учраас гурилын үнэ өрсөлдөөний зарчмаар шийдэгдэх тэр нөхцөл рүү бол ЗГ анхаарлаа хандуулна.

Дахиад давтаад хэлье. Тариалан эрхлэгчдийг эрсдэлд орохгүй байх тэр нөхцөл дээр ЗГ бодлогоо гаргаж ажиллана. Гэхдээ энийг зөвхөн гурилын импортын татварт тавьсан, өрсөлдөөнийг хумьсан, монополыг бий

болгосон хэлбэрээр асуудлыг шийдэхгүй. Өнөөдөр гурилын үнийг тогтоож байгаа 2-оос гуравхан компани байна. Зах зээлийнхээ 50-аас дээш хувийг нь атгаж байна. Давуу байдлыг олж байна. Нэг жил оруулсан хөрөнгө оруулалтаа нэг жилийнхээ урсгал зардал дээр бүтэн тавьчхаад, ашиг багатай алдагдал ихтэй мэтээр тайлангаа тавиад Засгийн газрыг олон нийттэй хууран мэхэлж, бизнес хийж байгаа энэ байдалтай эвлэрэхгүй ээ. Төрөөс их хэмжээний хөнгөлөлттэй зээл авдаг. Хүнсний хувьсгалын арга хэмжээний хүрээнд жишээ нь гурилын үйлдвэрүүд 2023 онд 101 тэрбум төгрөгийн зээл авсан байгаа юм, 6 хувийн хүүтэй зээл. Түүгээрээ хөрөнгө оруулалт хийсэн. Урт хугацааны хөрөнгө оруулалтыг нэг жилийнхээ зардал дээр тавьж, тайлан балансаа гаргаад үнээ хөөрөгдөж өсгөж байгаа энэ байдал бол ард иргэдэд зохистой харагдахгүй байгаа. Тийм учраас ЗГ энэ гурилын үйлдвэрлэгч нарын бодит үнэ дээр очих тэр нөхцөл рүү бол бодлогоо чиглүүлж ажиллана. Дахиад хэлье. Тариалан эрхлэгчдийг эрсдэлд оруулахгүй байх тэр нөхцөл дээр хамгаалах бодлогыг ЗГ хэрэгжүүлнэ.

Г.Тэмүүлэн: Ганболд гишүүн алга байна. Батсуурь гишүүн алга байна. Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ер нь энэ оруулж ирж байгаа Засгийн газраас оруулж ирж байгаа энэ хуулийн төслийг дэмжиж байна. Ер нь Амарбаясгалан сайдын саяын ярьж байгаатай ер нь 100 хувь нэг байгаа. Ер нь тэгэхдээ энэ ажлыг заавал энэ зуд хараад, хүлээгээд байх биш, эртхэн хийчих ёстой ажил байсан, оройтож хийгдэж байгаа ажил. Ер нь тэр түрүүний жишээг ч ярьж байгаа юм тэр. Би энэ Их Хуралд орж ирээд л ярьж байсан. Тэр цементийн хувьд яах вэ, зүгээр харж байсан энэ Хөгжлийн банкнаас баахан мөнгө зээл гаргачихсан байдаг. Түүнийгээ л хамгаалж л ард түмэн дээрээ татвар ноогдуулаад л ингээд л явж байгаа юм байна л гэж харж

байсан. Тэр цементийн үнэ нэмэгдээд л импортын татварыг нь авахгүй байгаад байсан, гаалийнх нь татварыг хэд 20 хувь байл уу. Бараг өндөр татвар байсан шүү дээ, цемент дээр.

Тэгээд энэ гурил тэжээлийн хувьд бид нар энийгээ яаралтай түргэн оруулаад баталчих хэрэгтэй байгаа юм. Хамгийн гол нь энэ нэгдэж нийлж чаддаг цөөхөн тооны энэ үйлдвэрлэгчид маань бүх ашгаа аваад, дээрээс нь энэ нийт иргэд дээрээ ингээд хуваагаад татвар болгоод ноогдуулчхаад байгаа байхгүй юу. Ер нь бид нар хамгаалах ёстой юмаа хамгаалах ёстой. Тэр улаан буудай тариалж байгаа тариаланчид маань үржил шим багатай, хатуу хөтүү уур амьсгалтай газар тариалж байгаа зовлонгууд байгаа. Тэгээд стратегийн бүтээгдэхүүн гэдэг утгаар нь хамгаалах ёстой байдаг бол хамгаалах ёстой. Тэгэхдээ жишээлбэл нэг бодлого гаргаад 2 асуудлыг зэрэг шийдэх гээд яваад байсан л буруу байгаа байхгүй юу. Жишээлбэл ард түмэн бол энэ ялангуяа манайх шиг жижиг орон, жижиг зах зээлтэй орон бол нээлттэй байж байж, нээлттэй байж байж энэ дэлхийн олон улсын энэ худалдаа наймаагаа хийж байж, энэ дээр аль болох түүн дээр энэ тарифын болон тарифын бус энэ саад бэрхшиэлийг нь гаргаж байж ард түмэн хожно. Хамгийн бага чанартай бүтээгдэхүүнийг хамгийн бага үнээр авах ийм л боломжийг ард түмэндээ бид нар олгох ёстой шүү дээ. Тэгээд харин тариаланчдаа хамгаалахдаа бол түрүүний олон өөр зөвхөн ингэж хамгаалахаас ганц шийдэл байгаа биш өчнөөн олон арга замаар хамгаалж болж байгаа. Жишээлбэл дэлхийн тэр цаг яг жил, жилийнх нь сар сараар ч байдаг юм уу, улирал улирлаар ч байдаг юм уу дэлхийн улаан буудайнх нь үнийн юу зах зээлийнх нь үнэ дундаж үнийг нь, үнэд доод талынх нь шал үнийг нь тавьж өгөөд ингээд хамгаалаад явах ч юм уу арга байна. Тэгээд цаашаа тэр харин энийг нь энэ улаан буудайг нь аваад, түүхий эд болгоод, гурилаа хийгээд өрсөлдөж байгаа үйлдвэрлэгч нар өнөөдөр яг л

дэлхийн зах зээл дээр байгаа компаниудын авч байгаа технологийг авч байгаа. Хэрэглэж байгаа жишиг цалин бага байгаа шүү дээ, манай ажилчдын цалин бага байгаа. Цахилгааны үнэ бид нар өнөөдөр том татаастай явж байгаа. Яг зах зээлийн үнээр бид нар цахилгаан нийлүүлэхгүй л байгаа. Тэгэхээр ийм хямдхан өртөгтэй өрсөлдөж чадахгүй байвал тэгээд л жамаараа хаах ёстой л байгаа байхгүй юу. Тэгээд энэ дэлхий тэр чигээрээ энэ Украин Оросоос улаан буудайгаа аваад л хэрэглээд л явж л байна шүү дээ. Тэгээд яах вэ, тэр стратегийн хувьд тэр аюултай, айхтар хүнд нөхцөл үүсээд л улаан буудайгүй болчих нөхцөлүүд гэж бас нэг айл гэр болгоомжлох ёстой, улс орон болгоомжлох ёстой байдаг бол тэр асуудал нь тусдаа асуудал, үгүйсгэхгүй байгаа. Тэгэхээр энийг бид нар нэг их тийм олон талаас нь бодоод байх юм биш өнөөдөр ер нь зүгээр ард түмнээ л бид нар энэ ам руу нь өдөр болгон өдөр болгон иддэг хоолных нь хамгийн том орцыг бид нар ингэж ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Цэрэнпунцаг гишүүн санал хэллээ гэж ойлголоо.

Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууя. 4 минут. Ганболд гишүүний микрофоныг өгье.

Г.Ганболд: Бид нар яах вэ, өнгөрсөн борооны хойноос цув нөмрөв гэдэг шиг л юм болж байгаа юм л даа. Оноос өмнө олон гишүүд санал хэлж байсан. Гэхдээ яах вэ, оройтсон ч гэсэн авах арга хэмжээний нэг нь зөв өө. Гэхдээ өнөөдрийн яг манай Монгол Улсын яг дотоодын үйлдвэрлэлээ дэмжих гээд гаргаж байгаа бодлого шийдвэрүүдийн л үнэн дүр төрх л энэ байгаа юм л даа. Сая Цэрэнпунцаг гишүүний хэлж байгаа шиг бид нар чинь цементийн дотоодын үйлдвэрлэлээ дэмжинэ гээд л цементийнхээ импортын татварыг нэмээд л. Тэгээд л бодит байдал дээр Эрээн дээр тонн нь 150 мянга байсан цемент энд 400, 500 мянга хүрээд л.

Эсрэгээр нь эсвэл гадагш нь түүхий арьс шир гаргахгүй гэж татварыг нь нэмж, тэгээд л өнөөдрийн дотоодын энэ байгаа арьс ширний цогц байгаа байдал яг л энэ. Тэрэнтэй адилхан яг энэ гурилын үйлдвэрлэлүүд бас дотоодын үйлдвэрлэлээ хамгаална, газар тариалангаа хамгаална гэж байгаад л гаргасан шийдвэрийн үр дүн өнөөдөр энэ л байна л даа. Тэгээд ШӨХТГ-ынхан очоод торгууль тавьсны маргааш нэг гурилын үйлдвэрийн захирал телевизээр ШӨХТГ-ынхан торгууль тавьсан учраас тэр торгуулийн мөнгийг хэрэглэгч л төлнө шүү дээ. Тийм учраас дахиад нэмнэ гээд л бүр үл тоосон шинжтэй тийм л байгаа байдал гаргаж байсан шүү дээ. Тэгэхээр зэрэг энийг бид нар ингэж авахаас өөр арга байхгүй.

Ер нь цаашидаа бол би энэ орж ирсэн үзэл баримтлал, оруулж ирсэн хуулийн төсөл 2 бол зөрөөтэй байх шиг байгаа юм. Нэг нь болохоор 7 сарын 1 хүртэл, нэг нь болохоор хугацаагүй юм шиг, энэ 2-ыг ч гэсэн би ойлгохгүй л байна л даа. Тэгээд бол татвараа төлөөд, гааль НӨАТ-ын гаалийн 15 хувь төлөөд орж ирж байгаа. Орж ирж байгаа хэчнээн тонн гурил байгаа юм бэ? Өнөөдөр Оросоос орж ирсэн. Тэгээд энэ татварыг тэглэснээр яг зах зээл дээр хэдэн төгрөгөөр зарагдана гэж тооцоолж байгаа вэ? Яг өнөөдрийн зах зээл дээр яг хэдэн төгрөгөөр зарагдана гэж тооцоолж байгаа вэ? Энэ нь бол яг хэрэглэгчийн гар дээр гэсэн үг л дээ. Хэдэн төгрөгөөр очих вэ гэдгийг л асуух гэж байгаа юм.

Тэгээд нөгөө талаасаа бол яах вэ, би Болорчулуун сайд эд нарыг салбарын сайд бол салбараа өмгөөлж хамгаалах нь зөв. Мэдээж салбарын сайд бол энэ салбарыг унагахгүй байх зорилготой, тайлбарлаж байгаа тайлбаруудыг нь ч гэсэн би ойлгож байгаа. Гэхдээ бол бас энэ Хэрэг эрхлэхийн даргын хэлж байгаагаар бол улаан буудай бол яг энэ гурилын өөрийн бүтээгдэхүүний өртгийнх нь дийлэнхийг эзэлж байхад ийм өндөр

байна гэдэг бол надад эргэлзээ төрүүлж байгаа.

Нөгөө талаасаа бол яг энэ тайлбарлаад байгаа энэ зарим нь улаан буудай тарихгүй рапс тарина энэ тэр гэж дарамталж байгаа байдал буруу шүү дээ. Энэ төрийн газар. Тэр битгий хэл зарим улс орнуудад төр юу тариалахыг нь шийддэг шүү дээ. Улаан буудай тарина, рапс тарина, тэдэн хувьд нь тарина, ашиггүй байх юм бол татаас өгнө, ашигтай байх юм бол татварыг нь нэмдэг ийм л зарчмаар явдаг шүү дээ. Тэгээд энэ зарчим руу оруулахгүй бол бас ингээд нэг юм хийх гэхээр нэг сөрөг бойкот хийдэг. Ийм юмнаас бид нар салахгүй бол цаашидаа бүх салбарууд дээр яг адилхан болох гээд байна.

Тэгэхээр дотоодын үйлдвэрлэлээ дэмжих нь зүйтэй ч гэсэн ер нь бол энэ дотоодын үндэсний үйлдвэрлэгч нарын энэ улс орныхоо өмнө ард түмнийхээ өмнө хүлээх үүрэг хариуцлага гэдэг юмыг нэг жоохон ухамсарлаж, ойлгуулж явахгүй бол төрөөр нэг шийдвэр гаргуулаад л ингээд эсрэгт нь ашгийн төлөө, ашиг олохын төлөө ингээд төрөөр татвар нэмэх эсвэл татвар тэглэх ийм бодлого гаргуулдаг юмнаас жаахан салах ийм цаг хугацаа болсон байх гэж ингэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Ганболд гишүүний асуултад хариулъя. Тодорхой яг нэг асуулт сууж байна. Гаалийн албан татварыг чөлөөлснөөр яг гурил хэдэн төгрөг болох вэ л гэсэн асуулт асууж байна. Энэ дээр хэн хариулах вэ? Амарбаясгалан дарга 5 номер.

Д.Амарбаясгалан: Өнөөдөр Боршоо боомтоор 5 мянган тонн импортын гурил орох зөвшөөрөлтэйгээр ажиллаж байна. Цагааннуурын боомтоор бас мөн адил 5 мянга, Арцсуурийн боомтоор нэг 800 тонн гурил орох ийм зөвшөөрлийг аваад ажиллаж байгаа юм. Энэний үр дүнгээр тариалалтаа хийгээд, хураагаад, гурилаа

үйлдвэрлээд, мөн дээрээс нь хэдэн мянган км тээвэрлээд, Монгол Улсад орж ирэхдээ импортын өнөөдрийн байгаа 15 хувийн татварыг төлөөд, тэгээд оруулж ирсэн компани нь ААН-ийнхээ албан татварыг төлсний дараа Увс аймгийн Улаангом хотод 50 кг-ын 1 дүгээр гурил 80 мянган төгрөгөөр зарагдаж байна. Гэтэл дотоодод үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнийхээ 90 хувийн өртгийг шингээдэг улаан буудайгаа 700 төгрөгөөр худалдаж авсан үйлдвэрт үйлдвэрлэгдсэн гурил 2800 төгрөгөөр килограмм нь зарагдаж байна. 50кг-ын-ын шуудайтай гурил 140 мянган төгрөгөөр зарагдаж байгаа юм. Тэгэхээр энэ бол иргэдийн худалдан авах чадварт маш хүнд сөрөг нөлөөллийг үзүүлж байна гэж байгаа юм.

Малын түүхий эд өөрөө үнэ унасан. Үнэ 2013 онд Засгийн газрын шийдвэр гарч боловсруулаагүй арьс шир, түүхий эдийг хилээр гаргахыг бол хориглосон шийдвэр гарсан. Үүнтэй холбоотой дотоодод түүхий эдийн үнэ бол унасан байгаа. Харин Засгийн газрын зүгээс өнгөрсөн 7 хоногт ОХУ-тай ЗГ хоорондын комиссын хурлыг Шадар сайд Хүрэлбаатар даргалаад хуралдаад ирсэн. Үр дүнгээр нь ОХУ малын түүхий эд, мах, сүү сүүн бүтээгдэхүүнийг татваргүйгээр авах нөхцөлийг бол бас хангахаар болж байгаа. Хөнгөлөлттэй татвартайгаар. Ингэхээр тодорхой хэмжээнд үнэд орох байх гэсэн ийм хүлээлт бол байна. Яг ингээд ярихаар мал мах өөрөө гурилаа, будаагаа, өргөн хэрэглээнийхээ бараа бүтээгдэхүүнийг худалдан авах боломжгүй болгож, малчдыг хүнд байдалд оруулж байгаа. Дан ганц малчид гэхгүйгээр иргэд маань өөрөө энэ өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн дарамтад орж байгаа юм. Тэгэхээр энэ авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнгээр шууд хэлэх юм бол алслагдсан бүс аймаг нутагт 50кг-ын шуудай гурил 140 мянгаар зарагдаж байгаа байдал нь 80 мянган төгрөг болж буурах. Түүнээс доошоо орох бүх нөхцөл нь хангагдана гэж ингэж бол үзэж байгаа.

Мэдээж дотоодынхоо зах зээлийг энэ үйлдвэрлэгч нар тариа будаа тарьдаг тариаланчдын эрх ашгийг хангах, хамгаалах асуудал бол чухал гэдэгтэй санал нэг. Гэхдээ хамгаалж байгаа нэрийн дор ард иргэдэд өндөр өртөгтэй дэлхийн зах зээлээс хэт давсан өндөр өртөгтэй, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнээр хангах бодлогыг ЗГ хэрэгжүүлэх нь буруу юм аа. Өнгөрсөн нэг жил гаруйн хугацаанд энэ ШӨХТГ-аас үндэслэлгүйгээр үнээ нэмсэнтэй холбоотойгоор торгууль, мөн анхааруулга сануулгыг бол удаа дараа гурилын үйлдвэрүүдэд өгсөн. Сая Ганболд гишүүний хэлдэгчлэн торгууль тавиад явахад нь араас нь шоглоом тоглоом хийдэг, басамжилдаг, шүүхэд өгдөг. Нөгөө асуудал нь хэдэн жил дамнаж шүүх дээр явдаг. Эргээд төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр дүнгүй болчхож байгаа юм.

Тэгээд энэ бүгдээс ер нь ЗГ сургамж аваад ер нь энэ монополын эсрэг үйл ажиллагааг ЗГ яамдын түвшинд буюу Эдийн засгийн хөгжлийн яамны бүтцэд оруулж ирэх нь зүйтэй юм. ШӨХТГ очоод акт тавиад хэрэгжихгүй байгаа бол үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй нь шууд ярьдаг тэр боломж нөхцөлийг яамдын түвшинд бодитой авч хэрэгжүүлдэг болох нь зөв юм гэж ингээж үзэж байгаа.

Би түрүүнд хэлсэн ганц гурилын салбар дээр энэ асуудал биш байгаа. Маш олон салбар дээр төрийн техникийн зохицуулалт, төрийн шийдвэрийн ард давуу байдлыг олж бизнес хийж байгаа энэ салбаруудыг цэгцлэх бодлого дээр бол ингээж ажиллах нь зөв өө гэж ингээж үзэж байгаа.

Г.Тэмүүлэн: Ганболд гишүүн нэмж тодруулъя. 1 минут.

Г.Ганболд: Бодвол энэ янз бүрийн тусгай зөвшөөрөл энэ тэр гэж байдаггүй байлгүй дээ. Бизнесийн бүх л хүмүүс оруулж ирэх байх гэж ингээж ойлгож

байна. Тэгэхээр манайд нэг зовлонтой юм ерөөсөө 1 үнэ өсчихөөрөө буцаж бууна гэж байдаггүй нэг зовлон байна аа. Одоо гурилын үнэ буулаа гэхэд байна шүү дээ нөгөө талх тарианы чинь үнэ буулгах тал дээр дарга аа, энэ хууль батлахын өмнө энэ талх нарийн боов, гурилан бүтээгдэхүүн хийдэг үйлдвэрлэлийн төлөөлөлтэй уулзаж ард иргэдийн нуруун дээрээс ч гэсэн бид нар төр ийм үнэ буулгах чиглэлээр анхаарч байна. Тийм учраас энэ бодит үнийг хэрэглэгчийн гарт буулгаж өгөх тал дээр нэг анхаараач гэдэг уриалга энэ уулзалтуудыг хийж энэ чиглэлийн л юм явахгүй бол тэгээд л буусан ч гэсэн талхны үнэ хэвээрээ байх юм тэгээд л хэцүү шүү дээ. Тийм ээ. Тэгээд энийг бас анхаарч ажиллах байх гэж ингээж бодож байна.

Г.Тэмүүлэн: Амарбаясгалан дарга 5 номер.

Д.Амарбаясгалан: Гурил өөрөө үйлдвэрлэж байгаа улсынхаа стандартыг хангаад баталгаат сав баглаа боодлоор бол баталгаажсан байдаг. Тийм учраас Монгол Улсад оруулж ирж зарж борлуулах эрх тусгай зөвшөөрлийг ЗГ, ХХААЯ-ны зүгээс олгохгүй байх ёстой гэдэг дээр байр суурь нэг байгаа. Ахиад л оруулж импортлох компаниудыг сонгон шалгаруулаад л цөөн тооны хэдэн компанид давуу байдал олгоод л явах юм бол энэ зах зээл өөрөө эрүүлжихгүй нь тодорхой. Тийм учраас арилжааны зориулалтаар, өрсөлдөөний зарчмаар асуудал шийдэгдэх нь бол зүйтэй гэж үзэж байгаа. Бодитой гурилын үнэ буурах тэр нөхцөлтэй уялдуулаад гурилаар үйлдвэрлэгдэж байгаа бүтээгдэхүүний зах зээлийн зүй зохистой үнэ хэрэглэгчдэд дарамтгүй, үндэслэлгүй өндөр үнээр зарагдах нөхцөлтэй холбоотой асуудал дээр мэдээж Засгийн газрын зүгээс хяналт тавьж ажиллана.

Г.Тэмүүлэн: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хэлэлцээж байгаа асуудал нэлээн л ярвигтай асуудал юм. Яг үнэнийг хэлэхэд. Туурга тусгаар үндэсний аюулгүй байдлаа хангана гэж үзэж байгаа улс орны хувьд бас ч хамаагүй чөлөөт эдийн засгийн арга хэлбэрээр юм яриад байж болдоггүй. Дан дамаа стратегийн шинж чанартай хүнс юман дээрээ бараг зуун дамжиж, аян өрнүүлж, үндсэндээ 65 жил зүтгэж байж, өнөөдрийн энэ бааз суурийг бий болгосон байхгүй юу. Одоо наадах чинь энэ арга хэмжээнээс болоод 2 жил доголдоход технологийн хийгээд техникийн боловсон хүчний бүх ур чадвар чинь алга болсон байна. Дахиад үүнийг босгоход ямар үнэ цэнээр босгох вэ гэдэг асуудал нэн төвөгтэй. Тийм учраас их бодож шийдэл гаргах ёстой асуудал шүү.

Би иргэд олон түмэндээ стандарт хангасан үнэ хямдтай гурил идэх ёстой гэдэгтэй санал нэг байгаа. Тийм учраас дэмжмээр байна. Гэтэл анхдагч үйлдвэрлэл нь газар тариалангийн үйлдвэрлэл, халуунд нь халж, хүйтэнд нь хөрж, тамаан цайж зүтгэж байж энэ салбарыг босгож ирсэн тэр бүхэл бүтэн салбарын хүмүүсийн амьдрал ахуйг яаж хамгаалах юм бэ. Гурилын үйлдвэрүүд үйлдвэрлэл нь зогсохоор будааны борлуулалт хязгаарлагддаг, будааны борлуулалт хязгаарлагдчихаар зэрэг түүнийг дагаад тариаланчид хүндэрдэг, тариалах талбай багасдаг. Дэлхийн зах зээл дээрх үнэ Монголын үнэ 2-ыг харьцуулахад бас учир шалтгаан бий. Ний нуугүй үнэнийг хэлэхэд. Бид чинь үржил шимийнхээ хувьд ч гэдэг юм уу, давхаргынхаа хувьд ч гэдэг юм уу хөрс нь бас нэлээн өөр хөрс шүү, энэ хойд ОХУ, Украин энэ тэрийг бодох юм бол. Тэнд чинь га-аас авдаг ургац чинь асар өндөр, нэгж бүтээгдэхүүний үнэ хямд гардаг ийм зүйл байхгүй юу. Тэгэхээр зэрэг ийм ийм юмнуудаа тал бүрээс нь бодох ёстой.

Би бол болохгүй байгаа юм нь юунд байгаа вэ гэхээр зэрэг 1 дүгээрт, монополын хуулиа бодох ёстой. Энэ

монополио задлах юмаа хуульчлах ёстой, бид хэд энэ бүрэн эрхийн хугацаанд банкны монополыг яаж задлах гэж оролдоо. Яг тэр арга хэлбэрээрээ харж энэ гол гол өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа үйлдвэрийнхээ монополуудыг задлах ёстой, 1.

2 дахь миний хараад байгаа зүйл бол бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцооныхоо асуудлыг харах ёстой. Одоо бид хэд сайхан гурил гаалийн татварыг нь чөлөөлөөд оруулаад ирнэ, болно. 1900-гаар орж ирэх юм шиг байна. Ер нь 1600-1900-гийн хооронд. Наадах чинь дахиад дамжлагаа аваад явахаараа зэрэг наадах чинь бараг 2000 гарч очих болно. Тэгээд одоо үр дүн яаж гарах юм бэ.

Зүгээр Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарсан тогтоол бол яах аргагүй цас зуд ихтэй байна. Тээврийн үйл ажиллагаанд бас хүндрэл үүсчихлээ. Өртөгжилт өндөр байна. Тийм учраас хил дагуух аймгуудад өөрийнх нь боомтоор өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн оруулаад ирэх нь энэ хүнд цаг үед өртгийг бууруулчих бололцоо байгаа юм байна гэж үзсэн. Тэрнийг дагаад 12 мянган тонн гурил оруулж ирэх шийдвэр гарсан юм билээ. Баяжуулсан гурил нь нэг 4,5 баяжуулаагүй нь нэг 800 орчим тонн ингээд нийтдээ 5 10-ны хэдэн мянган тонн гурил орж ирсэн юм уу гэсэн ийм тооцоо надад харагдаад байгаа юм. Тийм учраас үүнийг энэ талаас нь их зөв харж хийх ёстой.

Одоо Амарбаясгалан даргын ярьж байгаагаар бол үнэн. Авч хэрэгжүүлэх гэж байгаа арга хэмжээ хугацаатай хийгээд тоо хэмжээтэй болчихоор зэрэг эндэх үйлдвэрлэл түүнийг дагаад хүлээгдмэл гэдэг юм уу, нөхцөл байдал үүсдэг. Тэгэхгүй гээд хийчихээр зэрэг ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн ээ, 1 минутыг нэмье, асуултаа гүйцээгээд асууя.

Ж.Батжаргал: Тэгээд үүнийгээ яаж шийдэх вэ гэдэг асуудал байна. Тийм учраас би үүн дээр их тодорхой хариулт өгөөч ээ. Яг үнэ цэн нь хэдээр орж ирэх юм. Иргэд дээрээ хэрэглэгчид дээрээ ямар үнэ цэнээр очих юм. Бид чинь яг үнэндээ 210 мянган тонн будаа дотоодын тариалалт үйлдвэрлэлээсээ гурилын үйлдвэрүүд авчихсан. Сая 88 мянган тонн импортын будаа буюу чанар сайжруулагч оруулаад ирчихсэн. Ингээд 300 мянган тонн будаатай байгаад байгаа. Бид хэдийн гурилын хэрэгцээ нэг 290 орчим мянган тонн будаа тээрэмдчихэд хангачихна гэсэн ийм л тооцоолол өнөө жишсэн нормоороо гарч ирээд байгаа. Ийм л зүйл байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг дотоодынхоо хэрэгцээг бүрэн хангах бололцоо боломж нь байгаа.

Тэр 36 дугаар тогтоолын хүрээнд нэг их том юм авч хэрэгжүүлсэн. Тэр нь стратегийн нөөц ган гачиг ч болсон ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Амарбаясгалан дарга 5 номер.

Д.Амарбаясгалан: Гурил манай урд хойд хил дээр ирж байгаа үнэ 900 гаран төгрөгтэй байна гэдгийг би бас түрүүн мэдээлэл дээр хийсэн байгаа. Дотоодын зах зээл дээр импортоор орж ирээд зарж борлуулагдах энэ үнийг бол мэдээж төрөөс тогтоох боломжгүй. Харин энэ салбарын өрсөлдөөнийг бодитой бий болгох дээр харин төр боломжийг нь бий болгож, элдэв янзын хориглолт, хязгаарлалт, техникийн зохицуулалтыг хүчингүй болгох нь бол зүй зохистой гэж ингэж үзэж байгаа юм.

Яах вэ, гурил мэдээж стратегийн бүтээгдэхүүн. Яг ийм стратегийн бүтээгдэхүүн гэдэг байдлаараа айлгаад энэ салбар өөрөө илүү их хамгаалалт

дэмжлэг дунд орчихсон нь өнөөдрийн дэлхийн зах зээлээс 3 дахин өндөр үнээр зарагдах нөхцөл рүү оруулжээ гэж үзэж байгаа юм. Тэгэхээр энийг чөлөөлж өгөх ёстой. Цагаан будаа, элсэн чихэр маш олон төрлийн стратегийн бүтээгдэхүүнийг бид өнөөдөр заримыг нь 100 хувь, заримыг нь 50 хувь импортоор авч хэрэглэж болж байгаа. Хүнсний гурил мөн адил болох боломжтой.

Гэхдээ энэ гурилын үйлдвэрлэл хийх нөхцөлөөр нь хангах үүднээс тариалан эрхлэлтийг дэмжсэн бодлогыг ЗГ урт удаан хугацаанд хийж хэрэгжүүлсэн. Тэр мэдээж ач холбогдол, үр дүнгээ өгсөн байгаа. Сүүлийн дөрөвхөн жилийн хугацаанд л энэ гурилын үйлдвэрүүдийн хэт монополдох байдал зах хязгаараасаа давсан. Нэг жилийн дотор үнээ 73 хувиар хүртэл нэмж, өртөг шингээж байгаа. Ковид цар тахлын цаг үеийг далимдуулаад 2021, 22, 23 онуудад гурилын үйлдвэрүүд үнээ хэт их нэмчихсэн. Тэрнээс өмнө таны саяын хэлсэн газар тариаланг дэмжих атрын аян хөтөлбөр хэрэгжүүлж байсан зүйлс үр дүнгээ маш сайн өгч байсан. Эргээд харин төрийн дэмжлэг, энэ хамгаалалт хэтэрсний гор нь өнөөдөр ард иргэд дэлхийн зах зээлээс 2-3 дахин өндөр үнэтэй гурил идэх нөхцөл дээр хүргэжээ.

Тийм учраас ЗГ гаргах ёстой шийдвэрээ гаргаж байна. Мэдээж яг үүнтэй холбоотой Засгийн газраас шийдвэр гаргахад амар байгаагүй л дээ. Дотоодын үйлдвэрлэлээ яах вэ, тариалан эрхлэгчдийг яах вэ гэдэг асуудал нэг талдаа тулгарч байгаа юм. Нөгөө талаасаа энэ салбарынхаа бизнес эрх ашгийг хамгаалсан хэсгийн дайралтад маш өргөнөөр өртөж байгаа. Гэхдээ бид өөрсдийн нэр төр, өөрсдийн эрх ашгийг хойш нь тавьж байгаад ард иргэдийн энэ өндөр үнэтэй өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээл, түүнээс дотогшоо оруулж ирэх ханинд бид авачих нь зөв юм гэж ингэж бол үзэж байгаа.

Дахиад хэлэхэд тариалан эрхлэгчид ялангуяа улаан буудай тариалалт хийж байгаа салбарын эрх ашгийг хамгаалах чиглэл дээр бодлого хэрэгжүүлнэ. Гэхдээ Засгийн газрыг ард түмнийг улаан буудай тарихгүй шүү, тэрний оронд рапс тарина шүү гэдэг байдлаар дарамталж харьцах нөхцөлийг ЗГ хүлээж авах боломжгүй. Харин зүй зохистой харилцааг бий болгож, салбарын эрх ашгийг хамгаалж, дотоодынхоо үндэснийхээ аюулгүй байдлыг хангах чиглэл дээр хамтарсан бодлогыг хэрэгжүүлэх боломж бол байгаа гэдгийг бас энд хэлье.

Г.Тэмүүлэн: Батжаргал дарга нэмж тодруулъя.

Ж.Батжаргал: Амаргүй ч, амаргүй л байна. Шийдэл гаргах л ёстой байх. Гэхдээ 2 зүйл эхэлж харах ёстой юм шиг байгаа юм.

1 дүгээрт, энэ нэг дур зорog авирлаад байгаа монополюудаа задлах хуулиа нэг хармаар байна.

2 дугаарт, төрийн дэмжлэг юм үзүүлээд, хөнгөлөлт эдлүүлээд байгаа бол тэрүүгээр хүлээх үүргийнх нь гэрээг тодорхой болгож, гэрээ хангаагүй тохиолдолд хариуцлагаа тооцдог юм баймаар байна. ШӨХТГ үгсэн хуйвалдаад үнэ нэмчихжээ гээд хэдэн төгрөгийн торгууль тавиад асуудал нь зогсдог хэлбэрээрээ биш ямар үнэ цэнтэй юмыг үгсэж хуйвалдаад хэд болгочихсон юм. Буцаад яг тэр үнэ цэн дээрээ очдог эрх зүйн зохицуулалтаа хийхгүй бол энэ цаашаа явахгүй боломжгүй. Тэгээд ер нь бид хэд энэ 2 том гүрний голд байна. Бас эрс тэс уур амьсгал дотор байна. Дотоодын жоохон үйлдвэрлэл, эдийн засгийн идэвхжил, ажлын байр, хангалт, татварын бааз суурь энэ тэр гээд ярина л гэвэл үндэсний үйлдвэрүүдийг дэмжихээс өөр арга байхгүй. Гэхдээ үндэсний үйлдвэрүүдийг дэмжихдээ илүү өндөр үнэтэй бараа бүтээгдэхүүнээр иргэдээ хангахгүй байх бодлогынхоо хүрээнд

бидэнд бусдаас арай илүү харах төрийн зохицуулалттай тийм эрх зүйн зохицуулалт хэрэгтэй байгаад байх шиг байгаа юм.

Тийм учраас энэ тал дээрээ тэргүүн ээлжид тэмтрэх ёстой юм биш байгаа даа гэж би тэгж бодоод байдаг, тэгж хараад байдаг. Гурилын асуудлыг бараг 2 жил ярьцааж байгаа. Хэдүүлээ ийм болчихлоо шүү, будааны үнэ өсөөгүй байхад ингэлээ гээд л яриад бүх юм яригдсан. Бүх газрууд яваад л, шалгаад л, хэдэн төгрөгийн торгууль тавиад л илүү өөр авч хэрэгжүүлдэг арга хэмжээгүй ингэж явцаасаар байгаад өнөөдөр ийм байдал дээр аваад ирж байгаа юм. Тэгээд энэ нь буцаад анхдагч үйлдвэрээ үймүүлчих гээд бүхэл бүтэн босгосон салбараа баллачих гээд байгаа нь л хамгийн аюултай зүйл. Үүнийг бид дахиж босгож ирнэ гэхэд нэлээн төвөгтэй шүү. Тийм учраас их л ухаалаг шийдвэр гаргах ёстой. Үзэл баримтлал юмнуудаа их харах ёстой. Тэгж байж л энэ шийдлийг гаргах ёстой доо. Тэрнээс хэдэн улсууд санал бодол хэлээд шууд шийдвэр гаргачихна гэхэд би нэлээн л тийм төвөгтэй л юм байна. Ихээхэн судалгаа, тооцоолол юм хийж, хаана нь ямар зохицуулалт, ямар үнэ шингэлт юмнууд байх цохилттой юм энэ тэр гэдэг юмнуудаа нэлээн харж байж л асуудалд хандмаар л санагдах юм. Тэгээд ямар байдлаар шийд гардаг юм байгаа юм.

Г.Тэмүүлэн: Санал хэллээ гэж ойлголоо. Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Энэ гурилын үнийн асуудал бас 2 жилийн өмнөөс л иргэд олон нийттэй уулзах уулзалт болгон дээр л таныг 3 сарын өмнө ирэхэд байсан хүн дахиад л нэмэгдлээ гээд л. Тэгээд энэ ганц Монголчуудын бүтэн зовлон болсон юм билээ. Энэ яах вэ, энэ юун дээр бол малчдын гэж ингэж орж ирж байна л даа. Энэ бол би бол бүтэн Монголчуудын зовлон гэж хэлэх гээд байгаа юм. Энэ 10 сард би бас Байнгын хороон дээрээ үүнийг ярьж байсан. Яагаад ингэж байна вэ

гэхээр энэ төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг батлахад Монголбанкнаас нэлээн тийм бодитой судалгаанууд оруулж ирсэн. Инфляцын түвшин өндөр байгаад байна, өндөр байдаг гадаад, дотоод хүчин зүйлүүдээс гадаад хүчин зүйлүүд нь арилчихсан байна. Дотоод хүчин зүйл их өндөр байна. Дотоод дотооддоо дотоодын хүчин зүйл дотор дотооддоо үйлдвэрлэдэг гурил үнэ өндрөөс болоод гурил, гурилан бүтээгдэхүүний бараа бүтээгдэхүүний үнэ өдрөөс өдөрт нэмэгдээд, Монголчуудын хэрэглэдэг 20 нэр төрлийн бараанаас 12 төрөл нь гурилтай холбоотой байна. Тэр дотор б нь бүр тогтмол өссөн байна. Энэ 1 дүгээр гурилаасаа авхуулаад гуанзны таваг цуйван хүртэл 30 хувиар өсчихсөн байна л гэдэг ийм дүн байгаа байхгүй юу. Тэгээд үүнээс болоод дотоодын хүчин зүйл өндөр болоод, инфляц өндрөөс болоод Монголбанк бодлогын хүүгээ 13-д байлгаж байгаад өнгөрсөн 7 хоногт нэг 12 луу оруулаа шүү дээ. Түүнээс болоод яг энэ ковидын өмнө юмны үнэ нэмэгдээгүй байх үед энэ банкин дээр бизнесийн зээл 1,4-тэй буюу жилийн нэг 16 аравны хэдтэй байсан бол өнөөдөр 22 хувьтай, цалингийн зээл 18 хувьтай, тэтгэврийн зээл 15,6 хувьтай. Тэгэхээр өнөөдрийн энэ оруулж ирж байгаа асуудал зөвхөн малчдын асуудал биш ээ. Энэ бол Монгол Улсын энэ 3 сая 300 мянган хүн энэ тэтгэвэр авч байгаа, цалин авч байгаа, бизнес хийж байгаа энэ бүх хүмүүст чөдөр болж байгаа ийм асуудал байгаа юм.

Тэгэхээр энэ хуулийг би дэмжиж байгаа юм.

10 сард энэ асуудлыг Байнгын хороон дээр ингээд Монголчуудын зовлон нь энэ шүү гээд ингээд ярихад ШӨХТГ-ынхан юу гэж хариулсан гэхээр 100 тэрбум төгрөгийн дэмжлэг авчхаад үнээ ингэж нэмээд байгаа гэдгийг бид зөрчил гэж харж байгаа. Зөрүүлээд торгууль төлөөс ингээд тавихаар шүүхэд хандчихдаг. Шүүхийн процесс жил гаран

үргэлжилж байгаа. Энэ жил гаран хугацаанд энэ Монголчууд бүгдээрээ инфляцад идүүлээд л байж байгаа.

Тэгэхээр би ер нь зүгээр энэ өнөөдөр гурил, будаа, хивэг гэхээсээ илүүтэйгээр энэ бизнесийн энэ монополын асуудлууд, энэ Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө гэж энэ газар нэг их торгууль тавиад л араас нь элэг доог хийгээд л шүүхэд хандаад л ингэж уддаг энэ процессыг яаж тийм түргэвчлэх тал дээр би ЗГ бүр дорвитой тийм санаачилга гаргаасай гэж ингэж хүсэж байгаа юм. Яахаараа нэг төрийн байгууллага нь ийм дүгнэлт гаргачхаад байхад чи торгож байгаа бол би нэмнэ гэсэн ийм байдлаар хандаад энд нь бүхэл бүтэн Монголчууд хохироод байж байх юм бэ?

Ер нь төрийн зохицуулалт хэрэгтэй юм байна гэдгийг би бас энэ Их Хурлын танхимд орж ирээд нэг 2 жил гаран боллоо, анзаарч байна. Монголын тийзний үнэ дэлхийд байхгүй өндөр үнэтэй л гэж байсан. Яагаад ингээд байдаг юм доо гэсэн онгоцны шатахууны асуудал байсан юм байна лээ шүү дээ. Онгоцны шатахууны асуудлыг төр жосоохон оролцоод ирэхэд өнөөдөр тийзний үнэ яаж хямдарч Солонгос руу талдаа энэ чинь бараг сая хэдэн 100-гаар явж ирдэг ийм Монгол Улс болсон байна шүү дээ. Үүнээс хэчнээн Монголчууд хэдэн төгрөгөө хэмнэж байгаа бол. Тэгээд ийм нэг төрөөс дэмжлэг аваад ч байгаа юм шиг, эргээд ард түмнээ хорлоод ч байгаа юм шиг ийм салбарууд дээр энэ Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө энэ монополын асуудлууд, хариуцлагын тогтолцоог сайжруулах тал дээр ер нь ЗГ ямар бодлоготой байгаа вэ гэж би бас тодруулъя. Бусдыг нь гишүүд асуучихсан учраас би асуултаа ингээд цэгэлье.

Г.Тэмүүлэн: Идэрбат гишүүний асуултад хариулъя. 5 номер Амарбаясгалан дарга.

Д.Амарбаясгалан: ШӨХТГ өөрийн бас хуулиар ингээд зохицуулагдаад явж

байгаа. Үндсэндээ 2 өөр зүйлийг зохицуулалт хийх гэж нэг хичээгээд байгаа юм. Нэг талдаа бол яг хэрэглэгчдийн эрх ашгийг хангах, анхан шатны өрсөлдөөний зарчмыг бий болгох чиглэл дээр хяналт тавих үүргийг хүлээж байгаа юм. Нөгөө талдаа энэ салбарын монополын зах зээлийн монопол үүсгэж байгаа нөхцөлтэй тэмцэх ийм асуудал болчихоод байна. Тэгэхээр үндсэндээ хууль, эрх зүйн хувьд гаргаж байгаа шийдвэр өөрөө бодитой үр нөлөөгөө хангалттай хэмжээнд хүргэж чадахгүй байгааг л илэрхийлж байна гэсэн үг. Тэгэхээр үүнийг цаашаа эцсийн шийдвэр байдаг, гаргасан шийдвэрийн дагуу бодитой арга хэмжээг авч чаддаг тэр эрх зүйн орчны сайжруулалтыг бол хийх нь зүйтэй. Ямар хэмжээний бүтцэд энэ асуудлыг тусгах вэ гэж байгаа юм. Мэдээж макро эдийн засгийнхаа түвшинд бодлогыг бол Эдийн засаг, хөгжлийн яам дээр зохицуулалтыг хийж, монопол үүсэхгүй байх нөхцөлийн бодлогыг бол авч явах нь зүйтэй. Яг хэрэгжилтийн хяналт дээр энэ байгууллагын чадамжийг дээшлүүлэх байдлаар асуудалд хандах нь зүйтэй. Гэхдээ чадамжийг нь сайжруулж байгаа нэрийн доор төрийн хяналт шалгалтын дарамтыг давхардуулж болохгүй. Тэгэхээр энэ зохицуулалт дээр бид цаашид анхаарал хандуулж, хууль, эрх зүйн орч энэ сайжруулалтыг нь Улсын Их Хуралд оруулж батлуулахаар зорин ажиллая.

Г.Тэмүүлэн: Идэрбат гишүүн нэмж тодруулъя.

Ц.Идэрбат: Тийм, энэ гурилын үнэтэй холбоотой асуудал дээр ер нь жоохон бас судалгаа хийсэн юм, өөрийнхөө хэмжээнд. Жишээ нь Италид гэхэд гоймонгийн үнэ өсөөд яг Монголчууд шиг гурилыг 60 хувь хэрэглэдэг бол Италид бас тийм л юм байна лээ. Жоохон өсөөд ирээд л ирэх үед яг төр нь ажиллаад эхэлдэг юм байна лээ шүү дээ. Тэгээд эргүүлээд буулгадаг ийм юм байна лээ. Гэтэл манайд тийм тогтолцоо байхгүй. Одоо жишээ нь түүн дээр судлахад

Италийн тэр манайхаар ШӨХТГ юм шиг байгаа юм. Тэд нар маш сайн ажиллаж байгаа байхгүй юу. Хууль, эрх зүйн маш сайн зохицуулалттай. Гэтэл өнөөдөр гурилын үнэ нэмэгдлээ гэдгийг ХААЯ руу хандаад байгаа юм. Би энэ салбарын яам чинь үүнийг гурилын үйлдвэртэй байвал будаа ногоогоо сайн тарьж л байвал сайн учраас нэг талаараа сайн тарь гэхээд нөгөө талаараа битгий үнээ нэмээд бай гээд ингээд загнаад байж болохгүй нэг ийм зохицуулалт орчихоод байгаа юм. Тэгэхээр үүнийг хэн хагалах вэ гэхээр ШӨХТГ статус нь ямар байх ёстой юм. Энэ л хагалах ёстой л гэж миний хувьд ингэж хараад байгаа юм. Тэгээд энэ дээр бас хэрвээ амждаг бол энэ парламент дээр бас хэлэлцүүлэг юмнууд нь явбал бас ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Идэрбат гишүүн санал хэллээ. Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Зуд нүүрлэсэн үү гэвэл нүүрлэсэн, гамшигийн хэмжээнд гэж дүгнэж байх шиг байна. Гурил, будаа, тэжээлийн үнэ нэмэгдсэн үү гэвэл нэмэгдсэн. Тэгээд төр гэж байгаа учраас бодлогоо гаргаж, тохируулгаа хийж байх шиг байна. Хийхээс ч өөр аргагүй. Өнгөрсөн 10 сард би бас Болорчулуун сайдаас гурилын үнэ нэмэгдэж байна, та ер нь үйлдвэрлэгчдийнхээ талд байна уу, хэрэглэгчдийнхээ талд байна уу л гэж асууж байсан. Тэгээд үйлдвэрлэгчдийнхээ талд байна, татвар төлөгчдийнхөө талд байна л гэж ингэж хариулж байсан. Өнөөдөр 25 кг-ийн гурил 57, 8 мянга хүрчихсэн л байгаа л даа. Тэгэхээр яалт ч аргагүй төрийн бодлого тохируулах хэрэгтэй байна. Тийм учраас энэ оруулж ирж байгаа татвараас чөлөөлөх асуудлыг дэмжиж байна.

Тэгэхдээ бид нар ковидын үед үнэ тогтворжуулах бодлого хэрэгжүүлсэн. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн буюу бензин шатахуун, мах, гурил. Бензин шатахууны үнийг хатуу барьж ирж

чадаж байгаа. Харамсалтай нь мах, гурилыг чадаагүй. Өчнөөн хөнгөлөлттэй зээл өгсөн. Харамсалтай нь хэдхэн төрлийн салбарын компаниудыг дэмжсэн бодлого болж хувирсан. Махны үнэ буугаагүй, гурилын үнэ буугаагүй. Өнгөрсөн жил инфляцад 13,4 таван хувьд хүрч байхад махны үнийн 30, 40 хувийг нь эзэлж байсан. Одоо яг инфляц 7, 8 хувьд байна. Гурилын үнэ хэдэн хувийг нь эзэлж байна, инфляцад. Нэгд асууя.

Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд гурилын салбарынхан ААН үйлдвэрүүдэд хэчнээн төгрөгийн зээл, хэчнээн ААН-д олгосон бэ гэж нэг асууя. Мэдээллийн бас зөрөөтэй юм яваад байна. Өчигдөр бүлэг дээр Хөдөө аж ахуйн сайд гурилын үйлдвэрүүд тавхан хувийн ашигтай ажилладаг гэж ярьж байсан. Тавхан хувийн ашигтай. Хэрэг эрхлэх газрын даргын сайдын яриан дээр бараг 800 тэрбум төгрөгийн илүү ашигтай бизнес энэ салбарт эргэлдэж байна гэж ингэж ярьсан, сая. Энэ бас зөрөөтэй байна. Энэ бас иргэд олон нийтийг төөрөгдүүлж байна. Тэгээд 900 төгрөгөөр орж ирчхээд, 3000 төгрөгөөр, 2800 төгрөгөөр зарагдаж байгаа гурил дээр 5 хувийн ашигтай байна гэж ингэж тооцож яривал энэ чинь яаж тооцсон тооцоо юм бэ. Тэр үнийн өсөлт, өртөг хаанаас шингээд байгаа юм, хэн дээр шингээд байгаа юм. Энийг нэг тодруулж асууя.

Тэгээд хамгийн харамсалтай нь өөрсдөө хийж чадаж байгаа, тарьж ургуулж чадаж байгаа энэ гол бараа бүтээгдэхүүнээ ийм өндөр үнэтэй хэрэглэж байна гэдэг нь өөрөө их харамсалтай байгаа юм л даа. Түүнээс бензин шатахуунаа өөрсдөө хийж чаддаггүй, эрчим хүчээ өөрсдөө бүрэн хангаж чаддаггүй, гаднаас авдаг улс орны хувьд өндөр үнээр авахаас өөр аргагүй шүү дээ. Гэтэл бид нар чинь гурил, будаагаа өөрсдөө хийчихдэг, тарьчихдаг, ургуулчихдаг. Ингэсэн хэр нь ард иргэд нь 3 дахин өндөр үнэтэй гурил хэрэглэж байна гэдэг өөрөө үнэхээр энэ салбарт

монополын асуудал, цаашилаад төрийн оролцоо зайлиггүй шаардлагатай байна гэдгийг л харуулж байна.

Тийм учраас би энэ тал дээр Засгийн газраас авч байгаа. Үнэхээр үйлдвэрлэгчид үндэсний үйлдвэрлэлийн асуудлууд хөндөгдөнө. Үгүй ээ, тухайн үед нь тэгээд л ЗГ яаралтай арга хэмжээ аваад л буцаагаад энэ шийдвэр чинь хатуу мөнхийн шийдвэр биш шүү дээ. Буцаагаад хувь хэмжээг нь тогтоох асуудал яригдахыг үгүйсгэхгүй шүү дээ. Үнэ тогтворжоод ирэхээр.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн хэд хэдэн асуулт асуулаа. Амарбаясгалан дарга асуултад хариулъя. 5 номер.

Д.Амарбаясгалан: Гурил өөрөө энэ инфляцад маш өндөр нөлөө үзүүлдэг. Мах ч гэсэн. Үндсэндээ инфляцын 15 орчим хувийг гурил нөлөөллөө үзүүлдэг гэсэн энэ статистикийн мэдээлэл нь байж байгаа. Сая Идэрбат гишүүний хэлдэг маш олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндсэн суурь нь болдог. Тэр утгаараа энэ зах зээл дээр өөрөө гурилаас үүдсэн нөлөөллийг олон талаар тайлбарлаж ярьж болж байгаа юм.

Импортоор орж ирэх гурил кг-ийн үнэ 935 төгрөг байна гээд би түрүүн мэдээлэл хийсэн. Дотоодод үйлдвэрлэсэн гурил өөрөө 2600-3000 төгрөгөөр зарагдаж байгаа байдал 2 харьцангуй хол зөрөө өндөртэй байна. Тийм учраас зах зээл дээр өрсөлдөх боломжийг нь нээж өгөх үүднээс энэ импортын татварыг тэглэж, орж ирэх хэмжээнд нь квот тогтоохгүй л гэж үзэж байгаа юм. Цаашидаа энэ хэдэн төгрөгөөр зарагдах, тэр компани хэдэн хувийн ашиг олох зэрэг зүйл бол өөрөө зах зээлийнхээ зарчмаар шийдэгдэх учиртай.

ЗГ ААН, бизнес эрхлэгчдийг өндөр ашиг олж байна, бага ашиг олж байна, чи заавал тэдэн төгрөгийн ашиг олох ёстой гэж хандах нь бол зүй зохисгүй. Харин зах зээл дээр зах зээлийн зарчмаар

өрсөлдөөний замаар үнэ тогтоож байх тэр нөхцөлийг бүрдүүлэх нь Засгийн газрын туйлын зорилго байх ёстой. Тэгээд цаашаа түрүүн хэлсэн. Гурил, гурилан бүтээгдэхүүн ард иргэдийн амьжиргаанд дарамт болдоггүй, худалдан авах чадварт нь таарсан нийцсэн үнэтэй үнэлгээтэй байх нь хамгийн чухал алхам байна гэдэгтэй бол санал нэг байгаа.

Махны асуудал энд бас хөндөгдөж яригдаж байгаа. Ер нь энэ махны салбар, гурилын салбар өөрөө бодлогыг нь зөв болгож өгөхгүй бол алдаа дутагдлууд байна. Жишээ нь экспортод 130 гаруй мянган тонн махыг бэлтгэж гаргаж байгаа юм. Ямар нэг хязгаарлалтгүйгээр гарч байна. Гэхдээ тэр мах зөвхөн үйлдвэрийн аргаар бэлтгэгдсэн махыг авч гаргаж байгаа. Мөн улсын болон орон нутгийн нөөцөд тодорхой хэмжээний махыг бэлтгэх ийм шаардлага үүсдэг, тэрийг бүрдүүлдэг. Мөн л адил үйлдвэрүүдээр энэ үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махыг бэлтгэх нөхцөл рүү орчихдог. Гэтэл яг малчдын амьдрал дээрх нөхцөл байдал юу байна гэхээр гар аргаар хотондоо нядлах, цааш нь зах зээлд нийлүүлэх боломжийг хайж эрэлхийлж явж байдаг. Яг энэ зохицуулалтыг бүрэн авч чадаагүйгээс болоод тэр зах зээл рүү ченжүүд орж, зарим талаар төрийн, зарим талаар мах бэлтгэлийн компаниудын ажил үүргийг гүйцэтгээд явж байгаа. Энэ дээр өөрөө бодитой боломжтой, үнэ тогтоох боломжгүй. Малчдын гар дээрээс маш хямдхан авдаг. Хот, суурин газар авчирч зарахдаа нэлээдгүй өндөр үнээр зарж борлуулдаг. Энэ дунд өндөр ашиг олж байна гэж буруутгахын аргагүй. Гэхдээ энэ өөрөө зах зээл нь зөв зохистой, өрсөлдөөний зарчмаар ном, дүрэм, журмынхаа дагуу хийгддэг болох тэр нөхцөл дээр ЗГ анхаарал хандуулах ийм учиртай байгаа юм.

Бид он гараад 01 сарын 07-нд Засгийн газрын хурал хуралдаад энэ мах гар аргаар бэлтгэгдсэн махыг зах зээлд нийлүүлэх боломжийг бол нээж өгсөн юм

байгаа юм. Гэтэл харамсалтай нь яг энэ ажлыг хэрэгжүүлэх тэр Мах бэлтгэлийн компаниуд бол дутуу ажилласан. Зөвхөн экспортод гаргаж, өндөр ашиг олохын төлөөх анхаарал дээрээ хэт их төвлөрч ажиллаад дотоодынхоо зах зээл, хот, суурин газрын махны хэрэглээг тэнцвэржүүлэх ажил дээр бол бас дутуу оролцож байгаа ийм тал байгаа. Тийм учраас Засгийн газраас ХХААЯ-аар дамжуулаад бас энэ мах бэлтгэлийн компаниудтай байгуулсан гэрээнийхээ үүргийг биелүүлэх энэ шаардлагыг тавьж ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Хүрэлбаатар сайд алга байна. Жавхлан гишүүн асуулт асууя.

Б.Жавхлан: Би энэ Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн газрынхнаас асуух гээд байгаа юм. Та хэд маань ер нь юу хийж байв аа? Бүх аргаа барчихсан юм уу, яасан юм. Хүн байгаа биз дээ? Одоо ингээд та нарын ажил явахгүй болохоор энэ асуудал өөрөө ингээд хурцдаж орж ирж байна шүү дээ. Энэ ганц гурил дээр ч гарж байгаа асуудал биш. Бид нар олон бүтээгдэхүүн дээр ингэж гарч ирдэг. Энэ хэрвээ үнэхээр тэнд далд эдийн засаг яваад, үнийн өргөдөл яваад, хэт өндөр ашиг олоод монопол байгаа бол танай газар, та нарт зориулсан бүр хууль байгаа шүү дээ. Ямар ямар арга хэрэглэсэн юм. Тэгээд тэрэнд чинь үгэнд нь ороогүй юм уу. Ийм хүнд байдал руу оруулахгүй шийдэж яагаад болдоггүй юм бэ? Энэ асуудлыг ЗГ дээр байж байхад та нар ерөөсөө энэ дээр огт хариулт хэлээгүй, байгаа ч үгүй. Ийм маш харамсалтай маш хатуу шийдвэр лүү ингэж ЗГ-ыг ч тэр, Их Хурлыг ч гэсэн авчирдаг бол маш харамсалтай байхгүй юу.

Энэ үзэл баримтлалыг та нар харж байгаа байх. Энэ батлагдсан үзэл баримтлал дээр салбарын сайд, Сангийн сайд, энэ Хууль зүйн сайд нар ингээд баталчихсан энэ дээр 25 мянган тонны импортын квот нээгээд 07 сарын 01 хүртэл гээд ингээд энэ чинь гурил дээр интервенц хийж байгаа байхгүй юу.

Гурилын зах зээл дээр, үнэ дээр. Түр зуурын хугацааны интервенц хийж байгаа юм. Одоо ингээд орж ирэхдээ энэ чинь хугацаагүй, хэмжээгүй болчихоор энэ чинь бүр тогтолцооны асуудал болчихож байгаа байхгүй юу. Салбарын асуудал болчихож байгаа байхгүй юу. Интервенц биш. Та нар интервенц хийх ёстой байтал ингээд тогтолцооны асуудал руу чихээд орчихож байгаа юм.

Энэ гаалийн татвар энэ 15 хувь гэдэг чинь анх хэзээ үүссэн юм бэ гээд бодоод үзээрэй. Энэ Атрын-1, 2, 3 дугаар аян, 4 дүгээр аян хүртэл. Одоо энэ Төрийн нарийн бичгийн дарга сууж, хийж байсан энэ Ганибал дарга хүртэл өөрөө яг энэ атрын аяныг эхлүүлж байсан. Атрын аянаа хамгаалах гэж энэ гаалийн татварыг тавьж байсан. Тэгвэл одоо атрын аянаа дүгнэе. Атрын аян зорилгодоо хүрчихсэн юм уу? Одоо ХААЯ-ныхан байж байна. Атрын аян чинь дуусчихсан юм уу одоо тэгвэл. Атрын аян бүр хэрэггүй болчихсон юм уу? Газар тариалан бүр хэрэггүй болчихсон.

Бид нар гурилын үнийг тогтвортой байлгах нь чухал. Энэ өөрөө стратегийн бүтээгдэхүүн. Бидэнд энд хэрэглэдэг хэрэгсэл, хуулиуд өшөө их олон байгаа шүү дээ. Шууд ингээд импортын татвар луугаа яваад орчихоор цаана нь энэ чинь бэлтгэн нийлүүлдэг маш том салбар байж байна. Гурилын үйлдвэр гээд энэ арваадхан том үйлдвэр байгаа. Тэрний цаана чинь хэдэн 100 тариаланч, компаниуд, хэдэн 100 тариаланчид, тариалан дагаж амьдардаг маш олон ААН ийм бүхэл бүтэн тогтолцоо байгаа. Энэ атрын олон аянуудын чинь үр дүн. Түрүүн Батжаргал гишүүн хэллээ, бараг 60 жил гэж байна. Бараг 60 жил байх. Одоо ингээд эд нар маань ингээд 4 сард тариаландаа гарна. Одоо ингээд юу тарихаа мэдэхээ байчхаж байгаа юм, юу тарих юм бол. Намар нь ингээд худалдан авалт байхгүй учраас хаана борлуулахаа мэдэхгүй учраас. Энэ өөрөө ингээд 2, 3 жил явна. Одоо малчдын зээл гэж ярьж байна. Намар бид нар тариаланчдын зээл

ярина. Ингээд 2 жил явлаа, 3 жил явлаа, эргээд тэгвэл бид нар гаалийн татвараа буцаад тавихад энэ тариалангийн салбар чинь тэр чигээрээ дамнуурчихсан байна, бүр байхгүй болчихсон. Тэгэхээр өөрөө энэ чинь салбарын асуудал байхгүй юу, тогтолцооны асуудал болчихоод байгаа юм.

Тэгэхээр бид нар гурилтайгаа ноцолдох биш энэ бүр салбараар нь босоогоор нь ингээд татаж унагах ийм юм руу хэдүүлээ орж болохгүй байгаа юм. Тэгэхээр миний санаа бол энэ оруулж ирсэн үзэл баримтлал дээрээ хугацаатай ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Санал хэллээ гэж ойлгох уу, тийм ээ. Амарбаясгалан дарга хариулах уу. Амарбаясгалан дарга 5 номер.

Дээр нь шударга бус өрсөлдөөн нэмээд хариулаарай.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайдын асуултад хариулъя. ШӨХТГ-ын мэдээлэл дээр үндэслээд.

Үнийн зохиомол өсөлтийг бий болголоо, үгсэн хуйвалдаж үнээ нэмсэн нь тогтоогдлоо гээд акт тавьсан. Акт тавьсны араас түрүүн Ганболд гишүүн хэлж байсан. Алтан Тариа компанийн захирал Цэнгүүн билүү Цэлмүүн билүү нөхөр хэвлэлээр дамжуулаад даанаалаад сууж байсан. Тавьсан актын чинь төлбөрийг гурилынхаа үнийг нэмээд гаргаж авна даа гээд. Ингэж давартлаа гурил үйлдвэрлэгч нар томорчихсон. Монголын төрийг ард түмэнтэй нь нийтэд нь дарамталж байна шүү дээ. Бүх шатдаа хөнгөлөлттэй зээл, дэмжлэгийг авч, үйлдвэрлэл хийчхээд эргээд дэлхийн зах зээлээс 3 дахин өндөр үнээр гурил зарж байгаагаа гавьяа байгуулж байгаа мэт ойлгуулж, асуудал шийдвэрлэж зохицуулалт хийх гээд төр шийдвэр гаргах гээд тэгэхээр шантааж хийж, бойкотолдог энэ байдал бол ялангуяа гурил үйлдвэрлэлийн салбарт нэгэнт

тогтчихжээ. Үеийн үед Засгийн газрын шийдвэрт Улсын Их Хурлын хуульд шийдвэр гаргалтад нөлөөлөл үзүүлж явсаар байгаад ирчхэж. Ард иргэдээс сонгогдсон гишүүдийг зарим талаар буруу мэдээллээр хангаж, олон нийтэд буруу ойлголт төрүүлж, өнөөдрийн энэ даварсан байдал дээрээ хүрч ирсэн байна. Тэгэхээр ЗГ энэ шийдвэрээс ухрахгүй гэдэг ийм хатуу байр суурьтай байгаа.

ШӨХТГ акт тавихаас цаашаагаар арга хэмжээ авах боломжгүй байгаа юм. Чадлынхаа хэрээр хэмжээтэй торгууль, актыг тавиад явдаг. Эргээд нөгөөдхийг нь шүүхэд өгөөд, нөлөө үзүүлээд, 1 дүгээрт нь, хугацаа хождог, 2 дугаарт нь, өөрсдийн талд шийдвэр гаргах тал дээр нөлөөлдөг. Энэ нэгэнт тогтоогдсон зүйл. Тэгэхээр төр төмөр нүүрээ зарим хэсэгт үзүүлэх шаардлага яг энэ мэтчилэн бий болсон гэдгийг та бүхэн минь их зөвөөр ойлгоорой.

Мэдээж хэрэг ЗГ үндэснийхээ үйлдвэрлэлийг хамгаалах, дэмжих, дэмжихийн тулд татвар төлөгчдийн мөнгөөр хүүгийн зөрөөг олгох маш олон төрлийн арга хэмжээ яг авсан. Эргээд өндөр үнэтэй гурилаа хэрэглэж байна. Стратегийн бүтээх бүтээгдэхүүн шүү, энэ чинь. Үндэсний аюулгүй байдал шүү гэдэг нэрийн доор айдас төрүүлж, өндөр үнэтэй өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн хэрэглүүлж байгаа энэ байдалтай бол бид цаашидаа эвлэрэхгүй. Зах зээлийн зарчмаар, шударга өрсөлдөөний зарчмаар үнэ тогтоож явах энэ нөхцөл боломжийг бий болгох ёстой. Мэдээж энэ дундаас ашиг олж байгаа цөөн тооны ААН-үүд бол байгаа, ашиг олсныг буруутгахгүй. Гэхдээ зах зээл дээр өрсөлдөөн бий болгохыг бид нээх ёстой юм.

Г.Тэмүүлэн: Болорчулуун сайд асуулт асууя.

Х.Болорчулуун: Монгол Улс зах зээлийн нийгэмд шилжсэн. Аливаа юм бас зах зээлийн өрсөлдөөнтэй бас ингэж

байж бас үнэ тогтох ёстой. Тэрэнд бас хамаагүй хатуу төр оролцоод байх социализм шиг боломжгүй л дээ, тийм. Гэхдээ улс орнууд хүнсний зүйл дээрээ стратегийн хүнсэн дээрээ бол хатуу төрийн бодлого явуулдаг. Би олон жилийн өмнө бүр нэг Японд очоод тэрийг гайхаж байсан юм. Японы ХААЯ-ны түшмэл манай тариалангийн цагаан буудайн талбайн захад зогсчихоод энд юу цагаан будаа тарьснаас гаднаас Хятадаас ингэж оруулж ирэх нь 2 дахин 200 хувь гэсэн үг шүү дээ. Хямдхан шүү дээ гэхэд, би танайх энэ дээр би тэр үед залуу байлаа. Энд ингэж тарьж байсны оронд Хятадаар оруулж байхад яадаг байна, тийм хямдхан юм бол гэсэн чинь ингэж хэлж байсан, 3 зүйл хэлсэн. Нэгд, бид гол хүнснийхээ зүйлээр гаднын хараат байж болохгүй. 2 дугаарт, бид нар иенээр авахгүй гадаад валютаар авна. 3-д, хэрвээ хямдыг нь бодоод бид нар гаднаас авбал энэ олон тариалагчид ажилгүй бол нийгэмд өшөө их хохирол учирна, эдийн засгийн хохирол гарна гэдгийг манай эдийн засагч нар тооцсон байдаг юм. Эдийн засагч нар гэж хэлсэн шүү. Ингэж хэлж байсан. Тэр үнэхээр алсыг харсан, улс төр, эдийн засагчдын тийм бодлого тэр улс оронд нь явдаг юм байна гэдгийг бодож байлаа. Энэ 30 жилд Монгол Улс бол 97 оны Энхсайханы Засгийн газрын хувьд гаалийн татвараа бүх юман дээр 30 хувь байсан бүгдийг нь тэглэсэн. Аж үйлдвэр тэр чигээрээ унасан, одоо хүртэл бүрэн босож ирж чадаагүй ээ.

Тийм ч учраас өнөөдөр Монгол Улс бол үйлдвэрлэл хэрэглэгч орон болсон. Харин газар тариалан дээрээ Атрын 3 дахь аян хэрэгжүүлснээрээ 15 хувийн улаан буудайн дээр гурилан дээр татвар тавьсан. Төмс дээр 15 хувийн татвар тавьсан. Энэ 2 салбар бол бас өндийж ирсэн. Жилдээ нэг 70, 80-аас 100 хувь хангадаг болсон. Эргээд яг зах зээлийн жамаараа гэж явбал ОХУ-тай яг өнөөдрийн байдлаар өрсөлдөж чадахгүй. Яагаад гэвэл ОХУ хямд өртөгтэй бүтээхээс гадна өндөр ургац авдаг. Дайны дөнгөж өмнө дайны үед 2 жилийн өмнө

доллар, рублийн хани 68 байсан. Одоо доллар, рублийн хани 90 болчихсон. Тэгж рублийн хани унасны улмаас ганц энэ гурил, будаа гэхгүй бүх юман дээр манайхаас хямд байгаа юм. Энэ чинь их зөрөөтэй юм шиг харагдаж байгаа. Тэрнээс биш энэ үйлдвэрлэж байгаа газар тариалан ч тэр, гурил үйлдвэрлэгч ч тэр үгсэн хуйвалдаад үнэ зохиомол нэмсэн асуудал огт байхгүй ээ. Би энэ гэдгийг хэлье. Бас нэг яамны сайдын хувьд.

Энэ татварын албаны 23 оны мэдээлэл байна. Энэ дээр бол юу 2, 3 дахин 5 хувийн ашигтай ажиллаж байна шүү дээ. Энийг бас ингээд ЗГ ч гэсэн авч анхаарах хэрэгтэй юм даа. Тэрнээс биш зохиомол, хүний үгээр, ялангуяа тэр Шударга бус өрсөлдөөнийхөн 700 мянгаар өнгөрсөн жил будаа авна гэж юу яриад байгаа юм бэ. Өнгөрсөн жил саяас сая 200-гаар авсан шүү дээ. Улаан буудай тийм үнэтэй байсан. 4 дүгээр зэргийн улаан буудай 920 байсан. Гэхдээ миний хувьд бол бидний хувьд яамны бодлого бол тодорхой хугацаагаар, тодорхой квоттойгоор оруулъя. Интервенц хийе гэсэн дээр санал нэг байгаа. Тэрнээс хугацаагүй, хэмжээгүй ингэж оруулна гэдэг чинь өөрөө бол үндсэн газар тариалангаа татаад унагаачихна.

Газар тариалан гэдэг бол МАА, туслах аж ахуй, хөнгөн хүнсний үйлдвэрлэл бүх юмны үндэс болж байдаг. Тийм учраас олон улсад газар тариаланг ямар ч төрийн бодлогоор дэмжиж явдаг юм гэдгийг бас хэлэх байна. Энэ дээр бас их бодолтой хандахгүй бол болохгүй шүү гэж хэлэх байна.

Г.Тэмүүлэн: Хэлэлцэх эсэх асуудал байгаа. Кабинетын сайд нар, танхимын сайд нар бас зөрөөтэй мэдээлэл бас яриад, үл ойлголцол бас УИХ дээр Байнгын хороон дээр бас түрүүлээд авах бол энэ зохимжгүй байна. Тэгэхээр би кабинетынхаа зарчмаар ЗГ дотроо бас яриад орж ирж байгаа гэж харж байгаа. Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: 1, 2 зүйл л хэлж асууж тодруулмаар байна л даа. 1 дүгээрт нь, одоо яг хэлж хэлэлцэж байгаа, ярьж байгаа энэ тэжээлийн энэ гаалийн татвар энэ тэр гээд зүйл чинь нэг өнгөрсөн борооны хойноос цув нөмөрсөн л нэг юм болж байх шиг байна. Нэг цаг үеийн шинжтэй. Одоо тэглээд, тэр нь орж ирээд, аймаг сумд очоод малчны хотонд очоод, үүний үр шимийг үзтэл юу л байдаг юм бол. Уг нь бол энэ жилийн энэ нэг цас зуд, өнгөрсөн жилийн ган, энэ өвөл хүндрэх нь тодорхой л байсан шүү дээ. Тэгээд өнгөрсөн хугацаанд энийг бид нар уг нь бол авбал авахаар л өнгөрсөн намрын чуулган дээр манай гишүүдээс эхлээд зөндөө л ярьж байсан. Одоо тэгээд 1 өнгөрсөн хойно нь нэг сайн хүн болцгоох гэсэн нэг ийм л зүйл л яригдаж байна л даа.

Яг тэгээд бодит байдал дээр нэг хонийг 40, 50 мянган төгрөгөөр худалдаж авч байна гэж мэдээлэл гарч байсан. Үгүй ээ, 2 прессээс хямд, нэг шуудай хивгээс хямд мал, тэрийг тэжээгээд нөгөө эдийн засгийн утга хаана байна. Тэгэхээр энд бид нарт нэг ийм тогтолцооны том зүйл үнэхээр том өөрчлөлт, шинэчлэлт хэрэгтэй байна л даа. Одоо нэг бид нар гэнэт сэрсэн юм шиг нэг гаалийн тэд татвар тэглээд яг юу ч болох билээ. Нэг шуудай нь хэдэн төгрөгөөр хэмнэгдэх билээ. Энэ яаж бодлого болж очих билээ. Зүгээр л энэ нэг ийм цаг үеийн амиа аргацаасан нэг ажил хийсэн нэр зүүсэн, төр засаг анхаарсан нэр зүүсэн, үнэндээ бол нэг ийм хууран мэхлэлт л бид нар энд ярьж байна шүү дээ. Үнэндээ энэ малчны хотонд хэзээ очоод энэ ашиг шимээ өгөх юм.

Тэгэхээр энэ 2 дугаарт нь, ер нь бодлогын асуудал гурил гээд. Яг энэ саяын тайлан дээр 290 мянган тонн орчим гурил Монгол хэрэглэдгээс одоо дутагдчихсан нь ингээд гаальгүй оруулж ирмээр байна. Өнгөрсөн жилийн тайлангууд дээр ХААЯ-ны тайлангууд дээр 4, 500 мянган тонн улаан буудай авсан. Бүтэн жилийнхээ гурилын хэрэгцээг хангана гэж байсан,

тэр будаа хаачихсан юм, худлаа байсан уу. Элдэв янзын татаас олон зүйлд зориулсан тоо баримт байсан уу. Яг энэ дээр тийм дүгнэлт хийсэн зүйл байдаг уу? Өнгөрсөн жил ямар ч л байсан 9 сард Монгол Улс жилийн хэрэгцээнийхээ улаан буудайг авлаа л гэж байсан. Одоо тэгсэн чинь 200 мянган тонныг 200 хэдэн мянган тонныг хэрэглэдэг нь дутчихлаа. Жилээр ярих юм бол өнөөдөр 3 сар, 9 сар хүртэл жилийн хагас. Бараг тэр авсан, тарьсан, ургуулсан гэж байсан улаан буудайн чинь 50 хувь нь байхгүй юм биш үү. Энэ ямар учиртай тоо баримт хаана яваад байна вэ.

Дахиад дээрээс нь ер нь үүнтэй холбоотой өнгөрсөн хугацаанд хөдөө аж ахуйн салбарт оруулсан нийт татаас, хөнгөлөлттэй зээл элдэв ер нь энэ татаасны нийт хэмжээ ер нь хэд байдаг юм бол. 30 жил бид нар татаас өгөөд л. Энэ чинь улсын мөнгө, төрийн мөнгө гэж байхгүй шүү дээ. Тэр Сангийн яамны доор сейфт хийчихсэн мөнгөнөөс гаргаж өгч байгаа юм биш. Татвар төлөгчдийн мөнгийг л өгч байгаа. Нэг хэсгийнх нь мөнгийг нь аваад нөгөөд нь өгч байгаа. Тэгээд энэ мөнгөний үр шим, дахиад энэ нь явсаар байгаад ард иргэдэд гурилын үнийн нэмэгдэл болж иргэдэд л очиж байгаа шүү дээ. Энэ мөнгийг чинь инфляц болж дахиад энийг нөгөө талд нь ард иргэд энэ мөнгийг төлж байгаа, энэ зардлыг төлж байгаа. Тэгэхээр энэ бүхэн дээрээ бид нар нэг ингээд дүгнэлт хийгээд нэг систем системийн тогтолцооны гээд лаг юм ярихаа больё л доо. Ядаж нэг 1 жилийн дараахыг харсан бодлого хэрэгжүүлбэл яасан юм бэ? Тэрнээс өнөөдөр энд бид нар нэг их лаг өвөлжилт, хаваржилт анхаарсан, дүр эсгэсэн, үүний үр шим гэж үнэндээ байхгүй болчихоод байна шүү дээ. Тэр тусмаа нэг хонийг 40, 50 мянган төгрөгийн үнэтэй болчихож, хувийн прессээсээ хямдхан үнэтэй. Тэгээд яг худалдаж аваад тэжээгээд бас яг эдийн засгийн нөгөө утга учир нь яг бас яг юу болох билээ? Тэгэхээр энэ дээр нэг жоохон арай илүү нэг энэ чинь нэг улс орон цааш цаашид олон мянган жил, олон 100 жил

амьдардаг ёстой байлгүй. Тэгээд тэрэнд зориулсныгаа бодлого уг нь ярьдаг л болмоор байна. Яам нь, бодлого оруулж ирж байгаа хүмүүс нь. Түүнээс ингээж бие биеэ нэг хуурсан зүйл ингээд хэдий болтол бид нар ингээж ярьцаах ёстой вэ? Тэгээд саяын тэр асуултуудад тэр өнгөрсөн жилийн Монгол Улсын хэрэгцээг хангана гэсэн улаан буудай маань хаачсан бэ? Тэрнээсээ их ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Амарбаясгалан дарга 5 номер.

Д.Амарбаясгалан: Өндөр үнэтэй гурил хэрэглэж байна, хохь чинь гээд орхиж болохгүйг бол эрхэм гишүүн та ойлгодог байлгүй дээ. Ямар ч цаг хугацаанд шийдвэрийг гаргах ийм шаардлага үүсдэгийг бас та мэдэж байгаа байх. ШӨХТГ бүтэн 2 жил үйлдвэрлэгч нарын араас үнээ үндэслэлгүй нэмсэнтэй холбоотой асуудлаар зохих шийдвэрүүдийг авч хэрэгжүүлсэн боловч төрийн шийдвэр, төрийн байгууллагын шийдвэрийг үл тоож өнөөдрийг хүртэл явлаа. Засгийн газрын эцсийн арга хэмжээг авч өнөөдөр энэ асуудлыг хуулийн төсөл боловсруулж оруулж ирж байгаа юм. Нөгөө ухна ишигний зовлонг ойлгодоггүй гэдэг шиг яг ард иргэдийн амьдралд амьжиргаанд нөлөө үзүүлж байгаа гурилын үнийн өсөлтийг бид тоохгүй зогсож огт болохгүй. Байх ёстой боломжит үнээсээ 40, 50 хувиар өндөр болчихсон байгаа зүйлийг хараад сонгуулийн шоу юм байна, эс үгүй бол улс төрийн заль юм байна гэдэг байдлаар хойшоогоо зүгээр сууж бол болохгүй. Энд улс төр огт хамаагүй. Аль ч нам, аль ч цаг үед энэ үүргийг гүйцэтгэж байх ёстой. Харин энэ монопол болчихсон үйлдвэрүүдийн эрх ашгийг хамгаалах гэж янз бүрийн улс төр хийж Засгийн газрын шийдвэрийг үнэгүйдүүлэх гэсэн ийм оролдлогууд бол байж болохгүй ээ. Энэ бол өнгөрсөн борооны хойноос цув нөмөрч байгаа асуудал биш. Харин цаг хугацаанд нь. Ялангуяа энэ цас зудын нөхцөл байдал хүндэрчихсэн, ард иргэд, олон нийт дээрээс нь энэ Улсын Их Хурлын түвшинд

Засгийн газрын түвшинд энэ нөхцөлийг илүүтэй ойлгож байгаа цаг үед оруулж ирж байгаа байдал нь бол өнөөдөр бид эцсийн арга хэмжээ авах болчихсоны л жишээ юм гэдгийг бас хэлье.

Өнгөрсөн жил ер нь тариалан ургац хураалт бол ер нь ганц Монгол гэлтгүй дэлхий нийтээрээ тодорхой хэмжээний эрсдэлд орсон. Будааны болц хангалттай хэмжээнд хүрч чадаагүй. Яг хураасан будааны 40 орчим хувь нь хүнсний гурил үйлдвэрлэхэд тохирохгүй гэсэн ийм нөхцөл дээр бол очсон. Тэжээл, тэжээлийн зориулалтаар үйлдвэрлэгдэх тийм шаардлага руу бол явсан юм байна лээ. Энэтэй холбоотой ганц бид импортын татварыг тэглэх асуудлыг бас шийдэхгүй. Цаашидаа дотоодод хураалт хийгдсэн улаан буудайг олон төрлөөр гадагшаа бас экспортод орох тэр боломж нөхцөлийг нээж өгөх ёстой. Өнөөдөр Үндэсний аюулгүйн зөвлөл дээр жишээлбэл энэ улаан буудайн экспортыг хориглосон ийм шийдвэртэй л байж байдаг. Зах зээлийг нь нэгэнт импорт талд нь нээж, өрсөлдөөнийг бий болгохоор зорьж байгаа бол бас гадаад зах зээлд гаргах боломжийг нь бүрэн нээж өгөх ёстой гэдэг энэ бодлогоор бол бид ажиллана.

Г.Тэмүүлэн: Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл: Тэгээд гурилын үнэ өссөнд буруутан л хайгаад байх шиг байна л даа. Тэгэхээр энгийн нэг бид нарын ойлгож байгаа зах зээл чинь үнийг хэн нэгэн дарга цэрэг биш, хэн нэгэн биш тэр тусмаа өрсөлдөөнт зах зээл дээр эрэлт нийлүүлэлт тогтоодог оо. Тэр тусмаа нийлүүлэлт нь хангалттай, нийлүүлэлт нь чөлөөтэй, нийлүүлэлт нь өрсөлдөөнтэй байвал аяндаа боломжит үнэ дээр очдог оо л гэж үздэг шүү дээ. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд 400 мянган тонн будаа хурааж авлаа гэххэд тал нь байхгүй. Тэгээд энэ нийлүүлэлтийн хомсдолд орохоор энэ үнэ чинь өснө биз дээ. Төр засаг худлаа үнэн татаас есөн жорын тоо баримтад

тулгуурлаж мөнгө өгдөг. Энэ чинь тэр тариалалтыг худлаа хий өсгөж л байгаа шүү дээ. Дахиад дээрээс нь квот гээд тэр нийлүүлэлтийг дахиад сааруулчихна. Тэдэн хувь эдэн хувь оруулахгүй. Тэгээд нийлүүлэлт байхгүй болохоор энэ чинь энгийнээр үнэ угаасаа зах зээл дээр өсдөггүй юм уу энэ чинь. Тэгээд үүнд энэ зүгээр бодлогын алдаагаа тэгээд хэн нэгэн хүмүүс рүү чихчхээд эндээс нэг ийм улс төр хийгээд эндээс энэ дээр нэг бодлогын арга хэмжээ авч байна гэдэг яг энэ бодлого чинь л өөрөө л буруу л ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Ганибал гишүүн асуулт асууя. Ганибал гишүүний микрофоныг.

Н.Ганибал: Бүгдэд нь баярлалаа. Тэгээд нөгөө нэг зовох цагт тодорхой шийдлүүд гарах ёстой гэдэг байдлаар асуудлууд явж байна л даа. Ер нь Монгол Улсын эдийн засаг буруу явж байгаа. Өнөөдөр бид нар хэрэглээ талаа ярьж байна. Орлого олох тал дээрээ бас асуудлаа ярих ёстой. Тэгээд үндэсний үйлдвэрлэл нэртэй сүүлийн үеийн улс төрч голцуу хүмүүс түүхий эд бэлтгэгч, малчид, тариаланчдыг дээрэмддэг ийм л тогтолцоог бид нар бий болгочихсон. Өнөөдөр яг хөдөө маш хүнд байна л даа. Тэгээд зарж байгаа ганцхан бүтээгдэхүүнтэй. Тэр нь болохоороо үхсэн ямааныхаа арьсыг хуулаад зараад түүгээрээ гурил, будаа худалдаж авч байгаа. Сүхбаатар аймгийн малчдын хувьд. Яагаад тэр ямааных нь арьс өнөөдөр 20-30 мянган төгрөг байна вэ? Өмнө нь энэ 80 мянган төгрөг хүрч байсан. 70 мянган төгрөг хүрч байсан. Энийг ЗГ өнгөрсөн жил гаргасан ноолуурыг экспортод гаргахдаа зөвхөн самнасан ноолуурыг гаргана. 2024 оны 07 сарын 01. Энэ шийдвэрийн чинь үр дагавар өнөөдөр малчдын олж байгаа тэр зовлогоосоо олж байгаа орлогыг хүртэл боомилж байгаа юм. Тэгэхээр эдийн засгийн эрэлт, нийлүүлэлт, үйлдвэрлэл энэ бүх асуудлуудыг бид нар эргэж харах цаг нь болсон.

Бид гурилын үнэ ярингуут тариаланчдын асуудлыг яриад байна л даа. Энэ гурил үйлдвэрлэгч нарыг ярьж байгаа юм. Хэдэн тээрэмтэй хүмүүсийн тухай л ярьж байгаа юм. Яг тэр тариалан тарьдаг хүмүүсийн асуудал энд өнөөдөр яригдаагүй ээ. Тэгээд монополыг бий болгочихсон, бусдыгаа зах зээлээс шахдаг. Тэгээд яг өөрсдийнхөө дураараа зах зээлийг удирдан тоглодог энэ хүмүүсийн тухай өнөөдөр ярьж байгаа юм. Энэ орж ирж байгаа асуудал би зөв гэж бодож байгаа юм. Харин өнөөдөр яг үйлдвэрлэгч нар нь хэн юм бэ. Махыг бий болгож байгаа малчид байна. Улаанбаатар буудайг тарьж байгаа тариаланчид. Энэ хүмүүс дээрх бодлогын асуудал зайлиггүй байх ёстой. Өнөөдөр бид нар мал аж ахуйн энэ зуд бол малчдаа олон жил эдийн засгийг нь хоригт оруулсан, түүхий эдийг нь үнэ цэнгүй байлгасны үр дүн. Мал ихээр өссөн, бэлчээргүй болсон. Тэгээд их хэмжээний мал бэлчээр хомсодсон учраас өнөөдрийн энэ цаг зудыг давж чадахгүй хорогдож байгаа юм.

Бид нар үйлдвэрлээд зах зээлд гаргаж болж байгаа тэр махыг яагаад экспортыг нь хорьдог байсан юм бэ. Нэн ялангуяа сүүлд гаргасан 2 том шийдвэр байдаг. Махны үнийг өсгөвөл хар толгойгоороо хариуцаарай гээд Монголын малчдын зүрхэнд ортол хэлсэн нэг үг байдаг. Тэгэхээр энэ асуудал чинь өнөөдөр Монголын МАА-г сүйрүүлсэн шүү. Энийгээ бид нар дандаа бодож байх ёстой.

Арьс ширний үйлдвэр барина гэж байгаад улс төрийн учир шалтгаанаас болоод тэр арьс ширний үйлдвэрлэл яваагүй. Тэгээд өнөөдөр бүх арьс ширээ хаядаг болсон. Тэгэхээр орлого байхгүй. Тэгээд хэрэглэж байгаа бүтээгдэхүүн нь монополын гараар ороод хамгийн дэлхийн зах зээлээс 3 дахин илүү үнэтэй гурил бид нар хэрэглэнэ гэж. Тэгэхээр энэ чинь өөрөө ингээд эдийн засаг чинь өөрөө хэрэглээ болон орлого хоёроо орлогыг нь

боомилоод хэрэглээг нь нэмээд байгаа ийм л асуудал байна. Тэгэхээр энэ дээр бид нар зайлиггүй эдийн засгийнхаа энэ зөв зураглалыг зайлиггүй гаргах хэрэгтэй. Тэгэхээр энэ асуудлыг дэмжиж байна.

Г.Тэмүүлэн: Санал хэллээ. Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Энэ Шударга өрсөлдөөний хэрэглэгчдийн газар бас энэ 2023 онд бас энэ асуудлыг бас хэлж байсан юм. Тэжээлийн үнэ өндөр болчихлоо. Гурилын үнэ өндөр болчихлоо. Энэ импортын татварын асуудал энэ татварын асуудлаа нэг эргэж нэг харахгүй юм уу. Улсын Их Хуралд энэ асуудлаа оруулж ирэхгүй юм уу гэдэг энэ асуудлыг ярьж байсан. Тэгээд 1 юм ингээд л нэг зах зээлийнх нь журмаар явахгүй ингээд л байхаараа л нэг ийм асуудал үүсэж байгаа юм л даа. Тэгээд нөгөө дотоодын үйлдвэрлэлээ дэмжинэ гээд л бид нар нэг импортын татвар бусад татвараа нэмдэг. Ингээд нэг монопол зах зээлийг бий болгодог. Нөгөө монопол зах зээл бий болгосон нэг хэдэн үйлдвэрүүд нь хоорондоо үгсэн хуйвалддаг, үнээ нэмдэг, дархан байдал эдэлдэг гээд. Тэгээд эргээд энэ хэний нуруун дээр ирж байна. Ард иргэдийн нуруун дээр л ирж байгаа шүү дээ. Олон жил энэ асуудал ингээд л яригдсан.

Дэлхий нийтээрээ л энэ үл хөдлөх хөрөнгийн үнэ уначхаад байна. Тэгэхэд манайд барилгын үнэ ямар байна. Дэлхий нийтээрээ барилгын материалын үнэ уначхаад байдаг. Манайд барилгын материалын үнэ, цементийн үнэ ямар байна, метр квадратын үнэ ямар байна гээд. Манай энэ зах зээлийн тогтолцоо ер нь дэлхийн зах зээлийн тогтолцоогоос эсрэг ийм урвуу хамааралтай яваад байгаа байхгүй юу. Дэлхий нийтээрээ бүх юмны үнэ унаж байхад манайх эсрэгээрээ нэмэгдэж байдаг, өсөж байдаг. Тэгээд бид нарын энэ гаргасан энэ татварын тогтолцоо, нөгөө дотоодын үйлдвэрлэлүүдээ дэмжинэ гээд ингээд ард иргэдээ маш хүнд байдалд оруулдаг ийм

тогтолцоог л бид нар их олон жил хийж ирсэн юм байна лээ. Тэгээд цаашидаа бид нар энэ зах зээлийнхээ зарчмаар л явуулах хэрэгтэй. Тэр цемент дээр тогтоосон тэр өндөр татвараа бид нар болих хэрэгтэй. Энэ гурилын үйлдвэрүүд гурил гаднаас оруулж ирдэг, хивэг оруулж ирдэг энэ импортын татвар болон бусад татварынхаа энэ асуудлыг эргэж хараад энийг хөнгөлдөг бол хөнгөлөөд, тэглэдэг бол тэглэх энэ асуудлаа оруулж ирэх нь зөв асуудал. Ингэж байж л бид нар энэ зах зээлийг энэ хүнд цаг үеийг л авч туулна шүү дээ. Тэгэхээр би энэ оруулж ирсэн асуудлыг зөв гэж харж байгаа.

Цаашидаа бид нар энэ зах зээлийн нийгмээр явж, энэ гадаад зах зээлээ дэмжиж, гадаад зах зээлээ нээж өгөхгүй бол ингээд нэг гадаадаас нэг тусгаарласан аль болохоор нэг гадаадын юм орж ирэхээр эзлэгдэнэ ч гэдэг юм уу. Дотоодын үйлдвэрлэл явахгүй байна ч гэдэг юм уу, дотоодын үйлд үйлдвэрлэл хөгжихгүй байна ч гэдэг юм уу ийм байдлаар асуудалд ханддагаа болих хэрэгтэй юм байгаа юм. Үнэхээр цаашидаа дотоодын үйлдвэрлэл явна гэж бодож байгаа гадаадын үйлдвэрлэлтэй бид нар өрсөлдөж байж, үнээрээ өрсөлдөж байж л энэ зах зээл дээр л цаашидаа явна шүү дээ.

Өнөөдөр гамшиг болсон уу гэвэл гамшиг болсон. Би энэ төсвийн тодотголыг цаашидаа хийгээд явах нь зөв болов уу гэж бодож байгаа. Төсөв дутагдахад нэг төсвийн тодотгол хийх ёстой. Үнэхээр гамшиг давагдашгүй ийм хүчин зүйл болоход бас төсвийн тодотгол хийдэг. Үнэхээр энэ малгүй болсон иргэдийг цаашидаа яах ёстой юм. Малжуулах энэ хөдөлгөөнийг бид нар одоогоос эхлүүлээд эхлүүлэх ёстой шүү дээ. Одоо бид нар энэ 4 сар байна, 5 сар байна. Энэ УИХ дээр энэ төсвийн тодотголын асуудлыг яриад, энэ малгүй болсон иргэдийг судалгааг нь сайн гаргаж, тоо бүртгэлийг нь сайн хийгээд, ингээд малжуулах энэ ажлуудыг 8, 9 сард нь багтаагаад бид нар хийх ёстой шүү дээ. Хийх ёстой. Бүгдийг нь хий гэж

байгаа юм биш шүү дээ. Үнэхээр энэ цас зудад нэрвэгдсэн энэ айл өрхүүдийг бид харж үзэх ёстой шүү дээ. Төр л юм бол. Үнэхээр Үндсэн хууль дээр заачихсан байгаа шүү дээ. Мал бол төрийн хамгаалалтад байна л гэсэн. Малчид энийг л харж байгаа юм. Энэ чинь бүх нийтээрээ ингээд бүгдээрээ мал авъя гэсэн юм байхгүй шүү дээ. Үнэхээр энэ цас зудад нэрвэгдсэн энэ аймаг, сумын ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Санал хэллээ гэж ойлголоо. Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Надад асууж лавлаад тодруулаад байх юм байхгүй. Засгийн газрын шийдвэр гаргаад энийг хэлэлцүүлэхээр оруулж ирж байгаа юм. Би энэ төгсгөлд нь үг хэлье ч гэж бодож байна. Төгсгөлд нь үг хэлж байгаа юм. Ер нь эдийн засгийн бодлого зөв явж байж л улс орон хөгждөг, ард иргэдийн амьдрал, орлого нэмэгддэг ийм учиртай. Эдийн засгийн бодлого буруу явах юм бол эргээд энэ нь эдийн засгийн бүх төрлийн гажуудлуудыг үүсгэдэг. Сөрөг нөлөөг нь ард иргэд нуруундаа үүрдэг. Тэгэхээр хаасан, хорьсон, аливаа өрсөлдөөнийг нь алга болгосон энэ бодлого бол Монголын эдийн засагт хортой. Цөөн хэдэн хүн баяжих, баяждаг байх аа. Тэгээд дарга сайд нар болдог байх.

Энэ УИХ, энэ ЗГ энэ бодлогыг бид нар засаж явах учиртай. Хамгийн том жишээг нь би хэлье. Арьс шир 2014 онд энэ арьс шир гаргахыг хориглосон. 40 мянга, 50 мянга, 5 мянга, 10 мянга, 70 мянга хүрч байсан арьс ширүүд малчдын хотны гадаа хог дээр байж байгаа. Уг нь малчдын хувьд орлого олж байх ёстой зүйл нь одоо хог болоод байгаль орчноо бохирлоод явж байгаа. Хаадаг, боодог өрсөлдөөнгүй явсан энэ бодлогын үр дүн нь энэ шүү дээ. Одоо бодвол энэ манай Их Хурлын гишүүд бүгдээрээ л энэ өвөлжилт, хаваржилтын үед малчидтайгаа уулзсан байгаа. Ярьж байгаа зүйлүүдийнх нь нэг нь энэ. Бий болгодог бүтээгдэхүүнүүд нь үнэгүйдээд байдаг, хог болдог, худалдаж

авч байгаа бараа бүтээгдэхүүнүүдийн үнэ нь өсөөд байдаг. Түүн дээр нь тодорхой хэсэг хүмүүс өрсөлдөөнийг үгүй болгож, дандаа хааж хоосон бодлого явуулж түүн дээр нь цөөн хэдэн хүн мөнгөтэй болдог ийм л бодлого явж ирж байгаа.

Тийм учраас өнөөдрийн энэ асуудал энд яригдаж байгаа гэж үзэж байгаа. Ер нь цаашидаа энэ бид нар энэ өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх сая Энхтүвшин гишүүний ярьсан зүйлтэй би 100 хувь санал нэг байгаа. Бид нар энэ улсынхаа өрсөлдөх чадварыг нэмэхгүйгээр, нэмэгдүүлэхгүйгээр өрсөлдөөн дунд амьдарч сурахгүйгээр цаашидаа улс явахгүй ээ. Хиймэл орчин үүсгээд түүндээ амьдраад явдаг зүйл бол явдаггүй гэдгийг сая энэ ковидын 3 жил харууллаа. Дайн тулаантай байгаа энэ амаргүй цаг үе бидэнд харуулж байна шүү дээ. Тийм учраас энэ асуудлыг өнөөдөр 2 Байнгын хороо хамтарч хуралдаж байгаа. Үүнийгээ хамтарч суугаад хэлэлцээд зөв гарцаа гаргаад олоод явах нь зүйтэй.

Ер нь хөдөө аж ахуйн салбарт завхрал болоод байгаа энэ буруу бодлогуудыг бүгдийг нь засах ёстой цаг болсон. Дандаа эрх ашигт хөтлөгдөж, энэ салбарын бодлогыг явуулж, энэ Монгол Улсын хөгжлийг хойшоо татдаг энэ арга хэлбэрүүдээс салах ёстой шүү, ер нь бид нар. Тийм учраас бид нар өрсөлдөөнийг нэмэгддэг, салбаруудыг нээдэг, эргээд тэр ард иргэдийнхээ Монголын ард иргэдийг боддог энэ бодлогуудыг авч хэрэгжүүлж явахгүй бол цөөн хүйтэн хүний эрх ашгийг бодож хамгаалж явсаар байтал энэ улс орон эдийн засаг нэг өдөр л унана. Нуурсний жишээ ч бол үүнийг тод тодруун харуулж байгаа. Тийм учраас би Их Хурлын гишүүдийгээ үүнийгээ ЗГ оруулж ирсэн энийг дэмжээд, тэгээд хэлэлцэх асуудлынхаа хувьд асуудлуудаа яриад явах нь зөв болов уу гэсэн ийм байр суурьтай байна.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу?

Цэрэнпунцаг гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: Байдал амаргүй байна. Хямд гурил идэх ёстой байх. Хямд тэжээл өвс хэрэгтэй байх. Үүнийг шийдэх ёстой байх. Гэхдээ бас юмаа бодож ярьцгаагаарай. Чөлөөт эдийн засгийн тухай их сүрхий ярьцгаагаад 1992-2000 онд бүх үйлдвэрээ зогсоогоод, тоног төхөөрөмжийг нь төмрийн хогонд ачуулчихсанаа мартав. Нэн шинэ түүх. 2 масс том үйлдвэрлэгч улсын голд байж байж яаж энэ үндэсний аюулгүй байдлаа хангаж, авч гарах юм. Энэ олон улсыг бүгдийг нь гадагш нь ажиллах хүчний экспортод явуулаад байх юм уу, дотооддоо ажиллах хүчтэй байж нэмүү өртөг шингээж, эдийн засгаа идэвхжүүлэх юм уу гээд бодох юм бидэнд их байгаа. Тийм учраас би энэ нэлээн ул суурьтай асуудалдаа хандсан нь дээр байх аа. Гурилын үнэ өсөөд, тэжээл юмны хэрэгцээ байна. Гэхдээ бас юмыг таамгаар яриад байж болохгүй. 2023 оны ургац хураалтаар 434 мянган тонн улаан буудай хурааж авсан. 210 мянган тонныг нь гурилын үйлдвэр авсан. 90 мянган тонныг нь тэжээлийн үйлдвэрүүд авсан. 45 мянган тонныг нь энэ онд тарих үрдээ нөөцөлж авсан. 10 хэдэн мянган тонныг нь спиртийнхэн авсан. нэг 60 орчим мянган тонн нь тариаланчдын талбай дээр үтрэмд байсан. Тэр сая малын тэжээл рүү шилжих шиг байна. Ингээд тооцоо хийгээд үзэх юм бол 214 мянган тонн тэжээлийг дотоодоосоо үйлдвэрлэх бололцоо байсан. Тэрийгээ бид бүрэн гүйцэд ашиглаж чаагүй байгаа. Сая УОК шийдвэр гаргаж, ХАА-н корпорац дээр байсан 10.4 мянган тонн тэжээлийн будааг хүнд байгаа аймаг, сумуудын онцгой комиссоор дамжуулж малчид руугаа хүргэсэн. Одоо харин адуу, хонь бас тэнхрэх болоогүй байна. Ногоо амсаад улам дорддог. Тийм учраас тэжээлийн нэмэлт хэрэгцээ бидэнд шаардлагатай

байгаа учраас энэ асуудлыг би орж ирж байна. Зөв гэж дэмжиж байгаа юм гэж.

Гурилын хувь дээр бол анхдагч үйлдвэрлэлтэйгээ холбоотой үйлдвэрлэлээ. Би нэг хэдэн гурилын үйлдвэрийн захирлуудыг хөрөнгөжихийг хамгаалаад байгаа зүйл биш. 100 жил явсан 65 жил аян зарлаж босгож ирсэн газар тариалангийн салбараа унагачихаас бас хамгаалж байгаа юм. Тийм учраас тэр Засгийн газрын оруулж ирсэн хуулийн үзэл баримтлалынх нь хүрээнд тэр 25 мянган тонноор нь, тэр 07 сарын 01 гэдгээр нь асуудал яригдвал дэмжинэ. Тэгж яригдахгүй чөлөөтэй яривал би дэмжих боломжгүй гэдгээ энэ мэргэжлийн Байнгын хороог ахалж байгаа хүний хувьд өнөөдөр би зориуд дуугарна. Тэгэх ёстой. Энэ бол үндэстний эрх ашиг. Улсууд янз бүрээр ярьдаг юм. Өөрсдийнхөө бодлыг зөв болгох гэж, тийм юм биш ээ. Энд нэг хэдэн компанийн захирлын карманд орчихсон, тэрний эрх ашгийг хамгаалаад байгаа юм байхгүй. Наадах чинь яг 1992-2000 оны чинь бодлогыг давтах гээд байгаа учраас бас энэ амьдрал дундуур туучихсан хүний хувьд сануулж байгаа юм.

Тийм учраас дэмжиж боломгүй юмаа дэмжих боломжгүй ээ. Тийм учраас би ийм саналтай байна. Үзэл баримтлалынх нь хувьд асуудлаа ярьж гэвэл дэмжье, үгүй гэвэл дэмжих боломжгүй.

Г.Тэмүүлэн: Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Баярлалаа. Асуулт асуух гэсэн өөр Байнгын хороо давхцаад асууж чадсангүй. Тэгэхээр би энэ Засгийн газрын бодлого бол эрсдэлээ дагаж араас нь яваад байна гэж харж байгаа юм. Учир юу вэ гэхээр энэ жилийн зуд зурхан 11 сарын 04-ний өдөр Монгол орон даяар нэг мөр цас орсон. Ингээд мөсөн зуд болох нь бүр нэгэнт тодорхой байсан. Ингээд 11 сарын 12-ны чуулганаас хойш АН-ын бүлгийн гишүүд бид хэд 30 гаруй удаа өнөөдрийн ярьж байгаа бүх саналуудыг яг

бодитоор ярьж байсан. Өвс тэжээлээ аймагтаа татаач ээ. Тэнхээтэй туулах чадвартай машинуудаа 2 сумын дунд ч юм уу, 3 сумын нэгд аваачаач ээ. Улсын фондынхоо асуудлуудыг эртхэн цэгцлээч ээ. Тэр байтугай өнөөдрийн ярьж байгаа гурилын үнийг тэглэх асуудлуудыг Ерөнхий сайдын асуулга дээр асуухад үгүй гэж байсан, үгүй гэж байсан. Тэгээд бүгдийг үхээд дуусангуут нь тэгье гээд орж ирж байгаа байхгүй юу. Тэгээд өнөөдрийн энэ хурал дээр ЗГ нь дийлэх гээд байгаа юм уу, ХААЯ нь дийлэх гээд байгаа юм уу. Бид нараар ингээд олс татуулах гэж байна л даа. Засгийн газрын бодлого чинь өөрөө хүнс аж ахуйн бодлого нь Хүнс, хөдөө аж ахуйн яам дээрээ зангидагддаггүй юм уу? Тэгэнгүүт ХХААЯ нь үгүй гэж байх юм, ЗГ тэгье гэж байгаа юм. Би бүр энэ сүүлийн үед ойлгохоо байлаа.

Арьс ширний үнэ, махны үнэ, энэ гурилын үнэ нь өсөөд Монголын ард иргэд малчдын тариаланчдын үнэ өсөхгүй байгаа зүйлийг 2013 оноос эхтэй юм шиг сая Хүрэлбаатар сайд хэлж байна л даа. Тэгээд 16 оноос хойш 8 жил барилаа шүү дээ. Өсгөж байхгүй яасан юм тэгээд. Үгүй, үгүй тэгээд Ерөнхийлөгчид та нарыг хэн баригд гэсэн юм. Та нарыг битгий Ерөнхийлөгчид баригд гэж 65-аар нь 62-оор нь сонгууль өгсөн шүү дээ. Юу гэсэн үг юм, 8 жил саяхан танай ЗГХЭГ-ын дарга боодол бохь авч чадахгүй байна. Нэг нэхийгээр гэж байсан. Одоо авч байна гэсэн. Одоо боодол бохь ч авч чадахгүй л болчихсон байна шүү дээ. Тэгээд хэлэнгүүт дандаа уурлана. Үгүй 8 жил, яах вэ 13 онд болсон байя, 14 байя, 16 оноос хойш тэгээд асуудлыг шийдэхгүй яасан юм. Тэгээд 1 юм ярингуут л нэг зүүн хойд талын хар овоохой гээд, тэгээд 1 газар үг хэлэнгүүт танай намынхан ерөөсөө үг хэлүүлэхгүй юм, ямар учиртай юм? Та нарыг юм ярьж байхад чинь дуугардаггүй шүү дээ. Үгүй өөрөөсөө гээд байх юу байсан юм. Одоо хөдөөд юу хэрэгтэй байна вэ гэхээр байна шүү дээ. Энэ гурил, гахай гахай хялгасаа өгөөч би дээс томоод таныг амаръя гэдэг шиг мөд

хэрэгжихгүй. Одоо хөдөөд зээл, зээлийн хүү царцаах, банкнууд хэчнээн жил ашигтай ажилласан, банкнууд. Энэ банкнуудын эрсдэлийн санг шавхаж, тэр хөдөөгийн бараг амиа хорлох дээрээ тулаад байна шүү дээ.

Тэгээд энэ Засгийн газрын мэдээ, тайлан дандаа худлаа явж байна. Яаж байна вэ гэхээр Сүхбаатар аймагт сая гаруй мал үхчхээд байхад Монгол Улсын хэмжээнд 625 мянган малын хоригдолтой байна л гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр малчдын хэмжээнд 1.2 их наяд төгрөгийн зээл, зээлийн хүү ингээд яахаа мэдэхгүй болчхоод байгаа юм. Тэгээд энийг хэлэнгүүт банкнуудын талд орж байгаа асуудал биш. Үнэхээр банк эрсдэлийн сан гэж байдаг бол ард иргэдийн энэ зээл, зээлийн хүүг царцаагаач ээ, хөнгөлөөч ээ. Төрийн банк, Хаан Банкны асуудал.

Дээр нь малын индексжүүлэн даатгалаас авхуулаад бусад даатгалуудын эрсдэлийн санг шавхаач ээ. Ингээд үлдсэн туссаныг нь нэмэр хандив болох юм бол харин маргаашаас авхуулаад ядарсан ард иргэдэд нуруун дээрээс нэг боловч юмыг авч хаяна. Тэгэхгүйгээр өнөөдрийн гарч байгаа шийдвэр яам, ЗГ 2 нь зөрөөтэй байр суурьтай. Энэ нь Байнгын хороогоор ороод дийлээд тэгсээр байтал сонгууль болоод өнгөрөөд тэгээд намар болохоор нэг жоохон гурилын үнэ нь буурсан уу, буураагүй юу болоод л ийм асуудлууд байж байна.

Тийм учраас дахиад урьдчилж хэлж байгаа юм. 11 сарын үед хэлж байхад 4 сарын өмнө хэлж байхад бид нарын хэлж байсан арга хэмжээнүүдийг авч байсан бол өнөөдөр Монголын мал ингээж үхэхгүй байсан, ард иргэд ингээж зовохгүй байсан, зээлийн өрөнд орохгүй байсан. Тэгвэл ахиад хэлье. Ахиад энэ гурилын үнэ гэж байхынхаа оронд ахиад тэр банкнуудын эрсдэлийн сан, даатгалын эрсдэлийн сангаараа банкны зээлийг нь царцаах, тэглэх, хойшлуулах. Хойшлуулаад яадаг юм, тэр хүү нь улам л нэмэгдэнэ шүү дээ. Тэмээн дээр ямааны

гарз ямаан дээр янгианы гарз гэдэг. Тэгээд энэ болгоныг нь хэлэнгүүт ингээд яриад самууруулаад байх юм.

Тийм учраас мах ярингуут махны үйлдвэр, ченжийн асуудал л яригддаг. Гурил ярингуут гурилын үйлдвэр оруулдаг импортын компанийн л асуудал яригддаг уу гэхээс зэрэг яг малчин хүн, иргэн хүн үнэгүй гурил идэх, үнэтэй махаа үнэтэй зарах боломж байдаггүй шүү дээ. Ийм л зүйл ... /минут дуусае/

Г.Тэмүүлэн: Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Би товчхон дэмжиж байгаа саналаа хэлчихье. Угаасаа түрүүн хэлсэн, дэмжиж байна. Энэ орж ирж байгаа хуулийн үзэл баримтлалыг нь. Хамгийн гол нь бид нар өнөөдөр энэ ярьж байгаа энэ асуудлаа нэг болохоор нэг хувиа л нэг сонгууль ойртож байгаатай холбоотой юм. Улс төржүүлээд байх ерөөсөө шаардлага байхгүй. Бид нарын төрийн бодлого гэж ийм юм яваад байгааг л харуулаад байгаа байхгүй юу. Энийгээ ЗГ Хэрэг эрхлэх газраас ингээд Амарбаясгалан сайд оруулж ирээд засъя гэж байгаа нь сайн байгаа.

Хамгийн гол нь бид нар 2 өөр асуудлыг нэг бодлогоор шийдэх гээд л. Тэр тариаланчдын асуудлууд тусдаа асуудал. Тэр үнэхээр стратегийн ач холбогдолтой юм уу, байх ёстой бол байх ёстой. Өнөөдөр гурилын үнэ яриад байна шүү дээ. Гурилын үнийг бид нар энэ хэрэглэгчид зах зээлийн тэр цэвэр өрсөлдөөнд оролцоод нийлүүлж байгаа тэр нийлүүлэгчээс авч хэрэглэх хэрэгтэй байна л гэж байгаа асуудал байгаа байхгүй юу. Тэгэхээр өнөөдөр яг энэ жишээ авах юм бол өнөөдөр бид нар бензин тээвэрчдийн тээврийн үнэ зардал өндөр байна гэж яриад байгаа асуудлыг шийдэх гээд л тээвэрчидтэйгээ тээврийнх нь машин тэрэг тэгээд энэ замынх нь нөхцөлийг сайжруулах асуудал гээд өөр асуудал ярих байтал дахиад л давхиж очоод л нөгөө бензин рүү нь давхиж орж

ирээд байгаа юм шиг л байхгүй юу даа. Бид нар бензиний асуудлыг ярихгүйгээр тээврийн үнэ, тээвэрчдийн зах зээл дээр үйлчилгээ үзүүлж байгаа үнэ өндөр нам байна гээд голмдол саналтай байвал энэ дээр бид нар өрсөлдөөнийг нь яаж нэмэх вэ гээд бензин рүү нь орохгүйгээр бид нар бодлого гаргаж ярьж болохгүй байхгүй юу.

Тэгэхээр ийм юмыг бид нар хооронд нь хольж ирээд байгаа байхгүй юу даа. Тэгээд энийгээ салгаад тус тусдаа бид нар жишээлбэл нэг асуудал байвал нэг бодлого гаргаад биш, 2 тус тусад нь бодлого гаргаад энэ асуудлуудыг шийдэж болно. Тэр утгаараа гурил дээр бид нар өнөөдөр энэ гурил жижиглэнгээр, бөөнөөр гурил үйлдвэрлэгчид, нийлүүлэгчид зах зээл дээрээ өрсөлд өө л гэж байгаа. Энэ өрсөлдөөнийг хангая, хангах ёстой гэдэг энэ бодлогынхоо хүрээнд л энэ гаалийн энэ татварыг нь чөлөөлье гэж орж ирж байгаа гэж харж байгаа учраас дэмжиж байгаа.

Үнэ гэдэг юм байгаа юм. Өнөөдөр бид нар өнөөдөр энэ олон хардалт сэдэлт гаргаж ирээд л ийм өөр зөрөөтэй үнэ яриад л ингээд л манай юуны хөдөө аж ахуйн сайд ч гэлээ л нэг үнэ яриад л, тэндээс өөр үнэ яриад л ингээд байгаа бол энэ зах зээл чинь энэ нийлүүлэгчид нь энэ зах зээл дээр орж чөлөөтэй тэнд худалдан авагчдынхаа хэлэлцээрт орж байж зах зээл үнэ тогтоод, тэр тогтсон л хамгийн магадлалтай, хамгийн үнэн зөв байж болох үнэ байхгүй юу. Тэгэхээр бид нар энэ анхнаасаа энэ буруу бодлого гаргаж, энэ татаас тэр урамшуулал гэдэг юм өгч өнөөдөр тариаланчдаа бид нар манайх тэр хүнд нөхцөлтэй өндөр өртөгтэй улаан буудай үйлдвэрлэж байгаа бол өнөөдөр нэг тонн улаан буудайг ямар өртгөөр үйлдвэрлэж байгааг ерөөсөө хэн ч мэдэхгүй. Тийм учраас энэ үйлдвэрлэгч нь л нууна, хаана, худлаа мэдүүлнэ. Төр нь өө, хөөрхий минь энэ үнэхээр өндөр өртөгтэй байгаа юм даа гээд л татаасыг нь өгөөд байдаг. Тэгэхээр энэ улаан буудайгаа энэ байг

гэхэд энэ үйлдвэрлэгч нь өрсөлдөөнтэй энэ зах зээл дээрээ үнэ тогтоох нөхцөлийг нь үүсгэж өгчхөөд. Тэгээд бодит зах зээлийн үнэ ямар өртөгтэй өнөөдөр улаан буудай үйлдвэрлэгч тариалагчид үйлдвэрлэж байгааг тогтоочоод. Тэгээд энэ дээрээ бид нар тэр дэлхийн зах зээлтэй өрсөлдөх нөхцөл тэр дутмаг байгаа бол түүнийг нь бид нар нөхөж татаас урамшуулал өгч нөхөж ингэж өрсөлдөөн үүсгэхгүй бол ингээд энд гурил ярихаар зэрэг энд улаан буудай яриад байх юм. Юмаа ингэж хольж байж байж бид нар яаж асуудал шийдэх юм бэ?

Тэгээд эхлээд энэ гурилынхаа асуудлыг шийдчихье. Өнөөдөр энэ асуудлаа шийдээд дэмжээд явчихъя л гэж байна.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна.

23 гишүүн ирцэд орсноос 18 гишүүн байх шиг байна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалтыг явуулна.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулах ёстой байгаа.

ЗГ, би зүгээр ард нь онцлоод нэг зүйлийг хэлье. Сайд нар бас яг УИХ, Байнгын хороон дээр орж ирээд эсрэг тэсрэг байр суурьтай байна. Уг нь бол үзэл санаа агуулгын хувьд бол Их Хурал ч тэр, ЗГ ч тэр бүгд нэг байр суурьтай байгаа гэж харж байгаа. Гэхдээ орж ирэхээсээ өмнө тодорхой хэрэгжүүлэх арга зам дээрээ бол бас нэг өөр өөр үзэл санаа, байр суурь, үл ойлголцол үүсгэгдээд байгаа зүйлээ бол та бүхэн бас чуулган дээр орж ирэхээсээ өмнө цэгцлээрэй. Тэрнээс бид нарын нийтлэг эрх ашиг бол ерөөсөө л хямд гурил идье л гэдэг асуудал байна. Газар тариалангийн салбар нь хамгаалагдсан байх ёстой. Түүний түүхий эд нь бол нийлүүлэлт нь

тасралтгүй нийлүүлэгдэх ёстой. Үндэсний үйлдвэр байх ёстой л гэдэг суурь зарчим дээр бид нар бүгдээрээ нийлж байгаа юм. Тэгэхээр энийг тогтолцоогоор нь яг томоор нь харж газар тариалангийн салбар нь ч тэр, үндэснийх нь үйлдвэрлэлийн нь үйлдвэрлэл нь ч тэр эцсийнх нь бүтээгдэхүүн ч тэр хэрэглэгч дээр очоод хямд байх аль аль тогтолцоо нийтээрээ томоороо хамгаалагдсан байх л энэ бод болохыг бол та хэд маань бас хамтдаа УИХ, ЗГ хийх ёстой. Энийг бол хэлэлцэх эсэхийг нь шийдээд, хэлэлцүүлгийн явцад тодорхой зохицуулалт юунуудыг хийгээд ЗГ бол бүрнээр нь тогтолцоогоо хамгаалах тал дээр бол хариуцлагаа үүрээд ингээд явах ёстой л гэдэг бол би эцэст нь саналыг бол хэлэх гэсэн юм.

Санал хураалтыг явуулъя.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг нь дэмжье гэсэн саналаар нь санал хураалтыг явуулъя.

Гишүүд анхааралтай байгаарай.
Санал хураалт.

Үзэл баримтлалынх нь хүрээнд хуулийн төслийг 73.9 хувиар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон 2 Байнгын хорооны гишүүд болоод ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

Чуулганы хуралдаанд хуулийн төслийг хэлэлцсэн талаар 2 Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд 2 Байнгын хорооноос 1, 1 гарах ёстой юм уу. Саналаараа унших гишүүн байна уу? Байнгын хорооны чуулганы хуралдаан дээр. Туваан гишүүн.

Туваан гишүүнээр танилцуулна.

Хуулийн төслийг хэлэлцэж дууслаа. Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

17.22 цагт

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА